

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-47

1.Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох 4-47

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Батболд, О.Батнайрамдал, П.Батчимэг, Ч.Лодойсамбуу;
Тасалсан: Х.Баттулга, Э.Батшугар, Ж.Ганбаатар, П.Сайнзориг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох, гуравдугаар асуудал болох Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, экспортыг дэмжих зам, тээвэр, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах логистикийн оновчтой сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, агаарын тээврийг либералчлах, төмөр замын дэд бүтэц, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, авто замын сүлжээг өргөтгөх чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох асуудлуудыг салбарын сайд нар байхгүй байгааг мэдэгдэж, хойшлуулах горимын санал гаргав.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хэлэлцэх асуудлын дарааллын дөрөвдүгээр асуудал болох Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо хоорондын хамтын ажиллагаа, чөлөөт худалдааны гэрээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох, гуравдугаар асуудал болох Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, экспортыг дэмжих зам, тээвэр, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах логиستيкийн оновчтой сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, агаарын тээврийг либералчлах, төмөр замын дэд бүтэц, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, авто замын сүлжээг өргөтгөх чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох асуудлуудыг хойшлуулах горимын саналаар хураасан санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлуудыг хойшлуулав.

Нэг.Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, мөн хорооны Үнэ, тарифын газрын

дарга Б.Эрдэнэбулган, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн байлцав.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж 15 цаг 52 минутаас хуралдааныг удирдав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Жаргалан, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан, О.Цогтгэрэл, М.Энхцэцэг, А.Ундраа, Г.Лувсанжамц, Д.Энхтүвшин, Ш.Бямбасүрэн, С.Цэнгүүн, Р.Сэддорж, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, мөн хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Р.Сэддорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 25 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 25 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жаргалан: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Алдаржавхлан гишүүн ирсэн байна. Бадамсүрэн гишүүн ирсэн байна. Батболд гишүүн гадаад томилолттой байгаа юм байна. Батнайрамдал гишүүн гадаад томилолттой, Батсүмбэрэл гишүүн өвчтэй байгаа юм байна. Батчимэг гишүүн гадаад томилолттой, Бямбасүрэн гишүүн ирсэн жаргалан ирсэн, Лодойсамбуу гишүүн гадаад томилолттой, Мандухай гишүүн ирсэн, Мөнхсоёл гишүүн ирсэн, Соронзонболд гишүүн ирсэн, Ундраа гишүүн ирсэн, Найдлаа гишүүн ирсэн, Цогтгэрэл гишүүн ирсэн, Цэнгүүн гишүүн ирсэн, Энхтүвшин гишүүн ирсэн, Энхцэцэг гишүүн ирсэн. Албан ёсны ирц 52 хувьтай хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье гэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал та бүхэнд бас материалууд нь хүргэгдсэн байгаа.

Нэгдүгээр асуудал. Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох. Чойжилсүрэн сайд ирсэн байна.

Хоёрдугаар асуудал. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

Гурав. Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, экспортыг дэмжих, зам тээвэр, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах логистикийн оновчтой сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, агаарын тээврийг либералчлах, төмөр замын дэд бүтэц, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, авто замын сүлжээг өргөтгөх чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх зам тээврийн сайдын мэдээллийг сонсох.

Дөрөв. Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо хоорондын хамтын ажиллагаа, чөлөөт худалдааны гэрээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох гэсэн ийм 4 асуудал байгаад байгаа юм байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Нийтдээ 4 салбарын мэдээллийг сонсох асуудал өнөөдөр Байнгын хороон дээр орж ирж байгаа. Эхний салбар болох Эрчим хүчний сайдын мэдээлэл бэлэн болсон байна. Чойжоо сайд сууж бай тээ.

Тэгээд хоёрдугаар асуулт буюу энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох гэдэг дээр салбарын сайд нь эзгүй байгаа юм байна. тэгэхээр Төрийн нарийн бичгийн дарга бас яамных нь улсууд нь ирсэн байгаад байгаа юм байна. Тэгэхээр энэ асуудал дээр сайдыг нь байлгаж байгаад сонсох уу, аль эсвэл одоо байгаа хүрээнд нь сонсох уу гэдэг дээр гишүүд маань саналаа өгөх юм байна.

Тийм. Тэгэхээр энэ хоёрдугаар асуудал буюу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сайдыг нь байлгаж байгаад сонсьё гэдэг томьёоллоор санал хураах уу?

Тийм. 7. Тэгье. Ирэхгүй юм байна. Тийм 2 сайд байхгүй юм байна. Эдийн засгийн өсөлтийг тэтгэх гээд энэ 2024 онд зам тээврийн салбарт авч авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх Зам, тээврийн сайдын мэдээлэл дээр болохлоор бас салбарын сайд нь өөрөө байхгүй яах вэ холбогдох яамных нь хүмүүс нь байгаа юм байна. Тэгэхээр энэ 2 сайдын асуудлыг хойшлуулъя гэдэг томьёоллоор санал хураах тэгэх үү? Тийм, тэгэхээр энэ 2 мэдээллийг хойшлуулъя гэдэг томьёоллоор санал хураалт явуулъя. Хүрсэн 8 тийм.

Тэгэхээр санал хураалт.

Санал дэмжигдээгүй. Саяын энэ санал хураалтаар санал дэмжигдээгүй тул санал хураалтын дүн зөвшөөрсөн 50 хувь, татгалзсан 50 хувь. Тэгэхээр албарын сайд нар нь байхгүй байгаа хэдий ч яг холбогдох яамдынх нь албан тушаалтнуудаас өнөөдрийн хуралдаанаар мэдээллийг сонсохоор шийдвэрлэлээ.

Дөрөв дэх асуудал нь болохлоор Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо хоорондын хамтын ажиллагаа, чөлөөт худалдааны гэрээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох байсан. Үүн дээр Энхтүвшин гишүүн яг энэ асуудлыг сонсьё гэсэн албан бичгээр саналаа ирүүлсэн юм байна. Тэгээд саналаа хэлнэ үү. Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Тийм, тэгэхээр юу бас яг энэ нөгөө 2 хөрштэй холбоотой асуудал учраас хэлэлцээ бас яг ид явж байгаа үед уг нь би зүгээр Байнгын хорооны даргад шаардлагатай хаалттай хэлэлцье гэж ярьж байсан юм. Тэгэхээр одоо яг хэлэлцээрийн юм нь бас явж байгаа учраас яг ил байдлаар яриад хэрэггүй юм уу, тэгээд энийг хойшлуулъя гэсэн саналтай байна.

Б.Жаргалан: Санал дэвшүүлсэн Энхтүвшин гишүүн санал гаргалаа. Тэгэхээр энэ 4 дүгээр асуудлыг хойшлуулъя гэсэн бас санал хураалт дэгийн дагуу явах ёстой юм байна. Тэгэхээр 4 дүгээр асуудлыг хойшлуулъя гэсэн санал хураалт.

Саяын санал 57.1 хувиар дэмжигдэж хэлэлцэх асуудлын жагсаалтаас дөрөв дүгээр асуудал хойшлогдлоо.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байхгүй тээ? Хэлэлцэх асуудалдаа орьё. Мөнхсоёл гишүүний микрофон.

Б.Мөнхсоёл: Туваан сайдын танилцуулах ёстой асуудал байгаа шүү дээ. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөж гээд энэ сайд нь байхгүй байгаа юм чинь энэ асуудлыг бас хойшлуулах ийм горимын санал гаргаж байна.

Б.Жаргалан: Сая хэлэлцэх асуудал дээр бас яг наадах дээр чинь санал хураалт явуулаад тэгээд дэмжигдээгүй. Тийм тэгэхээр сайдгүйгээр наад асуудлыг чинь бас хэлэлцэхээр болсон байгаа. Санал хураалт сая явсан. Яах уу, горимын саналаар дахиад санал хураачих юм уу?

Тэгвэл горимын санал санал дээр, Мөнхсоёл гишүүний гаргасан горимын санал дээр дахин санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаа бас давхар гаргах ёстой юм байна шүү. Мөнхсоёл гишүүний микрофон.

Б.Мөнхсоёл: Би нөгөө ирцдээ орчхоод гараад явчихаар эсрэг хүчин болчихоод байна. Баярлалаа санал сонссонд. Тэгээд түрүүний санал хураалтыг хүчингүй болгох ийм горимын саналыг давхар гаргаж байна. баярлалаа.

Б.Жаргалан: Тэгэхээр сая санал хураалтыг хүчингүй болгох санал дээр санал хураана. Санал хураалт.

Өмнө нь хэлэлцэх асуудал дээр хураасан санал хураалт хүчингүй боллоо. Тэгэхээр сая Мөнхсоёл гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хүчингүй болсон хувь 64.3. Тэгэхээр дахин санал хураалт явуулах нь.

Хэлэлцэх асуудлаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээлэл, Зам, тээврийн сайдын мэдээллийг хасах буюу хойшлуулах тал дээр ахиад. санал хураана.

64.3 хувиар дэмжигдлээ.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээлэл, Зам, тээврийн сайдын мэдээлэл өнөөдрийн хуралдаанаас хойшлогдлоо. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэгдүгээр хэлэлцэх асуудлын хүрээнд Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэнг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Сайдын микрофоныг нээж өгнө үү. 4 номер.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүд, боловсруулах аж үйлдвэрийг дэмжих бүс нутгийн тэнцвэрт хөгжлийг хангахын тулд эдийн засгийн суурь салбар болох эрчим хүчний салбарт шинэчлэлт хийх, томоохон зорилтыг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлж, том чадлын эх үүсвэрүүд барих, бүс нутгууд, бүс нутгуудад сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрүүдийг барих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 5325 Мвт-ын цахилгаан эрчим хүчний 1778 мвт-ын дулааны эрчим хүчний экспортын зориулалттай 5000 Мвт-ын цахилгаан эрчим хүчний чадал бүхий нийт 35 эх үүсвэрийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээр зорилт дэвшүүлсэн. Эдгээр төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газрын 4 жилийн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний системээс суурилагдсан хүчин чадал 92 хувиар нэмэгдэхээр байна.

Эдгээрээс хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдсэн төслүүд гэвэл Бөөрөлжүүтийн 300мвт-ын ДЦС-ын эхний ээлжийн 150мвт-ын блокийн барилга угсралтын ажил 90 хувьтай. Баянгийн 660мвт-ын ДЦС-ын эхний ээлжийн 330мвт-ын блокийн барилга угсралтын ажил 6 хувьтай, Хөвсгөл аймгийн Мөрөнгийн 10мвт-ын нарны цахилгаан станц барилга угсралтын ажил дууссан. Улсын комисс хүлээн авах шатанд явж байна. Багануур дүүрэг 50мвт буюу 200мвт цаг батарей хуримтлуурын станц, барилга угсралтын ажил дууссан. Тосонцэнгэлийн 30мвт-ын ДЦС-ын эхний ээлжийн 9мвт-ын блокийн барилга угсралтын ажил 90 хувьтай. Сүхбаатарын 70мвт-ын ДЦС-ын барилга угсралтын ажил 15 хувьтай тус тус үргэлжилж байна.

Улаанбаатар хотын дулаан хангамжийг шийдвэрлэх ажлын хүрээнд 112мвт-ын хийн тархмал эх үүсвэрийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа бол Дулааны III дугаар цахилгаан станцын суурь дээр шинээр 300мвт-ын цахилгаан, 395мвт-ын дулаан үйлдвэрлэх шинэ станцыг ОХУ-тай хамтран хэрэгжүүлэхээр, Дулааны II дугаар цахилгаан станцын дэд бүтцийг ашиглан 300мвт-ын цахилгаан, 395мвт-ын-ын дулаан үйлдвэрлэх шинэ станцыг нийслэлийн хөрөнгө оруулалтаар барихаар, Дулааны 4 дүгээр цахилгаан станцыг 500 тонн цаг буюу 210мвт-ын дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай зуухаар өргөтгөх төслийг төслийн хөрөнгө оруулалтаар тус тус бүтээн байгуулахаар ажиллаж байна. Мөн мөрийн хөтөлбөрт бүс нутгууд болон хэрэглээ үйлдвэрлэлийн төвүүдийг холбох 220 киловольтын 1821.4км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байгуулахаар төлөвлөсөн ба 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам урт 2 дахин нэмэгдэхээр байна.

Үүнд хөрөнгө оруулалт нь шийдэгдсэн Чойр, Сайншандын 220км цахилгаан дамжуулах агаарын шугамын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байгаа бол Багануур-Чойрын 188км зам дамжуулах агаарын шугам, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 400км цахилгаан дамжуулах агаарын шугамын санхүүжилтийн асуудлыг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр холбогдох гэрээ хэлцлийн ажил үргэлжилж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх тухай бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд, Дунд хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны хөтөлбөр, Богино хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх томоохон

бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүд харилцан уялдаатай төлөвлөгдөн хэрэгжиж байна.

Сэргээгдэх эрчим хүчний талаар

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадал нь 311мвт-ын байгаа бөгөөд үүнээс 130мвт-ын нийлбэр чадал бүхий 10 нарны цахилгаан станц, 150 мега ваттын 3 салхин цахилгаан станц, 26 мегаваттын 6 УЦС-ууд сүлжээнд цахилгаан эрчим хүч нийлүүлэн ажиллаж байна.

Эдгээр эх үүсвэрээс 2023 онд нийтдээ 772.6 сая квт. цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж нийлүүлсэн. Эдгээр нарны цахилгаан станцаас нэгдсэн сүлжээнд 1квт цаг эрчим хүчний үнийг 483-580 төгрөг. Энэ бол долларт шилжүүлэх юм бол 14.2-17.3 центээр, салхин станцаас 1квт цаг эрчим хүчийг 320-323 төгрөг буюу 9.4-9.5 центээр тус тус худалдан авч байгаа нь дулаан цахилгаан хослон үйлдвэрлэдэг ДЦС-уудын үйлдвэрлэлд нь нийлүүлж буй дундаж тарифаас 4-6 дахин өндөр байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд 2015, 2019 онд тус тус нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Тус хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсгэвэрүүдийн тарифын дээд хязгаарыг нарны станцын хувьд 1квт цаг нь 12 америк цент, салхин станцын хувьд 1квт цаг нь 8.5 ам америк цент байхаар тус тус тогтоон дээд хязгаар, доод хязгааргүй болсон.

Мөн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг Эрчим хүчний яамнаас тогтоосон техникийн нөхцөл нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үнийн саналаар өрсөлдүүлэн шалгаруулах зохицуулалттай болсон. Тус хуулийн дагуу Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 200мвт хүртэлх нарны цахилгаан станц, нийт 300мвт-ын салхин цахилгаан станцын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг үе шаттайгаар эрчим хүчний системийн техникийн боломж ирээдүйн төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

3. Эрчим хүчний үнэ, тарифын шинэчлэлийн талаар

Эрчим хүчний сайдын 2024 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн А/210 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах болон эрчим хүчний салбарын үнэ, тарифын өөрчлөлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллууллаа.

Эрчим хүчний салбарын үнэ, тарифын шинэчлэлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцтай уялдуулах, индексжүүлэх талаар саналыг боловсруулан Засгийн газар Улсын Их Хурлын зарим гишүүдийн түвшинд танилцуулж эхний удаад салбарын алдагдлыг бууруулах байдлаар үе шаттай нэмэгдүүлэх шийдвэрт хүрсэн.

Олон нийтэд эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлын талаар буюу үүнд эрчим хүч үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэдэг талаар, эрчим хүчний хэрэглээний өсөлт, үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлаас хэдийн давсан

талаар, үйлдвэр, компаниудын их урсгал засварын ажлын явц, хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй байдлын талаар болон боловсон хүчний асуудлаар телевиз, цахим сүлжээгээр мэдээ, мэдээллийг хүргэх компани ажлыг 10, 11 дүгээр сард зохион байгуулснаар эрчим хүчний үнэ цэнийг иргэддээ ойлгуулах чиглэлээр ажилласан.

Мөн Монгол Улсын онцлогт тохирсон эрчим хүчний салбарын реформыг хэрхэн хэрэгжүүлэх талаар эрдэмтэн судлаачид, зөвлөх, мэргэшсэн инженерүүд, салбарын үе үеийн удирдах ажилтнууд болон одоо үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын удирдлага, ТББ-ын төлөөллийг оролцуулсан олон талт уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж байна.

Эдгээр зөвлөгөөнүүдийн үр дүнд салбарын реформыг 2 шаттай хэрэгжүүлэх. Үүнд:

1. Үнэ, тарифын шинэчлэлт хийх.

2. Салбарын бүтцийн реформ хийхийг зөвлөж байна.

1. Үнэ тарифын шинэчлэлийг эхний ээлжид салбарын алдагдлыг өртгөөр нөхөх хэмжээнд хүргэх, хэрэглэгчийн тарифыг эрчим хүчний үйлдвэрлэлийг өртөгт нь нийцүүлэх, цаашид тогтмол индексжүүлж байдлаар шийдвэрлэнэ. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний дундаж тарифыг 30 орчим хувиар нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.

Хэрэглэгчийн цахилгаан, дулааны үнэ, тарифт өөрчлөлт орж, цахилгааны тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд Улаанбаатар хотын дулааны тарифыг 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдөхөөр төлөвлөсөн.

Тухайлбал, цахилгааны дундаж тариф 1квт цаг тутамд 216 төгрөг байгааг 280 төгрөг болгож, 29.6 хувиар, дулааны тариф 1 гега килокалори цаг тутамд 33.9 мянган төгрөг байгааг 63 мянган төгрөг болгож, 85.9 хувиар тус тусын өөрчлөлт оруулахын зэрэгцээ айл өрхийн хэрэглээнээс хамаарч шаталсан тариф, оргил цахилгааны тариф нэвтрүүлэх зэрэг тарифын шинэчлэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрсний уурхай болон эрчим хүчний үйлдвэр компаниуд нийт 355 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах тооцоотой байсан бөгөөд улсын төсвийн 2024 оны тодотголоор 131 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос гадна 11 дүгээр сарын 15-ны өдрөөс тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор борлуулалтын орлого 63 тэрбум төгрөгөөр нэмэгдэж улмаар алдагдлын хэмжээ 161 тэрбум төгрөг болж буурах урьдчилсан тооцоотой байна.

Цаашид 2025 онд нүүрсний уурхай, төмөр замын тээврийн салбар болон эрчим хүчний салбар алдагдалгүй болж, эрчим хүчний урт хугацаат зээл хэвийн төлөгдөж эхлэх бөгөөд 2025 оноос үнэ, тарифын индексжүүлэлтийг хэрэгжүүлснээр эрчим хүчний салбарын оны эхэнд байсан 357 тэрбум төгрөгийн хуримтлагдсан богино хугацаат эх үүсвэргүй өр төлбөрийг 2027 оны эцэст буюу 3 жилийн хугацаанд төлж барагдуулж дуусах боломж бүрдээд байна.

2.Эрчим хүчний салбарын бүтцийн реформыг эрчим хүчний зах зээлийн загварыг тодорхойлсноор хийх бөгөөд одоо ашиглаж буй 1 худалдан авагчтай зах зээлийн загварыг цаашид шинэчлэх шаардлага, бөөний зах зээлд шилжих боломжийн нөхцөл байдлын шинжилгээг хийхээр төлөвлөж байна. Харьцангуй бага хүн амтай, үйлдвэрлэл хөгжөөгүй байгаа цаг үед өрсөлдөөн үүсэх болох эсэхийг сайтар судлан шинжлэх шаардлага зүй ёсоор тулгараад байна.

Энэхүү дараагийн зах зээлийн загварыг тодорхойлсноор хууль, эрх зүйн орчныг шинэчлэх үзэл баримтлал бий болно.

3.Эрчим хүчний реформ чухал хэсэг нь цэвэр эрчим хүчний дотоодын эх үүсвэрийг хөгжүүлэх асуудал бөгөөд эрчим хүчний сайдын 2024 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн А/235 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэл цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд хүргэхийн тулд нэгдсэн сүлжээнд шинээр барих өргөтгөх шаардлагатай цахилгаан дамжуулах өндөр, нам хүчлийн шугам сүлжээ, дэд станцуудын хүчин чадал, байршлыг тодорхойлох, эрчим хүчний хүч тархмал эх үүсвэрийн төслүүдийн нэгдсэн сүлжээний горим ажиллагаатай уялдуулан хөгжүүлэх байршил, хүчин чадлыг тодорхой болгох хувилбар, тооцооллуудыг хийж, дүгнэлт боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд энэ онд сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн төслийн шалгаруулалт хийх орон зайг тодорхой болгохоор ажиллаж байна.

Мөн эрчим хүчний шилжилт буюу уламжлалт эх үүсвэрээс ногоон сэргээгдэх эх үүсвэрт шилжихийн тулд урт хугацааны стратегийн төлөвлөлт хийхээр олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

4.Салбарын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын талаар

Монгол Улсын эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах, ажлын явцад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах, мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсэг Эрчим хүчний сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

ДЦС-уудын үндсэн тоноглол болох 65 зуух, 45 труба генератораас 2024 оны 12 сарын 17-ны өдрийн байдлаар ажилд 57 зуух, 40 труба генератор, бэлтгэлд 5 зуух, 2 труба генератор, засварт 3 зуух, 3 труба генератор байгаа бөгөөд системийн горим ажиллагаа хэвийн байна.

Эрчим хүчний салбарын 44 үйлдвэр, компаниудын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах үндсэн болон туслах тоноглолын их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар дунджаар 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Нүүрсний нөөцийг 2024 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр гэхэд бүрэн бүрдүүлж ажилласан ба 12 дугаар сарын 17-ны байдлаар нийт 704.8 мянган тонн нүүрсний, 5548 тонн мазутын нөөцтэй байна.

2025 оны 12 дугаар сарын байдлаар төвийн бүсийн ДЦС, дулааны станцууд нь 7484 мянган тонн нүүрс үйлдвэрлэлд хэрэглэхээр төлөвлөснөөс 7689 мянган

тонн буюу 7 сая 683.9 мянган тонн нүүрс хэрэглэж, нүүрсний хэрэглээний өсөлт, төлөвлөгөөтэй харьцуулахад 2.3 хувийн өсөлттэй байна.

Эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын хувьд 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт “Багануур” ХК дээр 90 хувь, “Шивээ-Овоо” ХК дээр 92 хувь, “Шарын гол” ХК дээр 89 хувийн гүйцэтгэлтэй байна. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын гол” ХК-уд нь оны эхнээс станцуудад 8.7 сая тонн нүүрс нийлүүлсэн бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөн үетэй харьцуулахад 7.6 хувийн өсөлттэй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголоор нийт 131 тэрбум төгрөгийн татаасыг шийдвэрлүүлсэн бөгөөд Эрчим хүчний сайдын 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/200 дугаар тушаалаар баталсан санхүүгийн дэмжлэгийг өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлтийг бүрэн хангах, нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, импортын эрчим хүч худалдан авах, тарифын алдагдлыг бууруулах, бэлтгэн нийлүүлэгч төлөх төлбөр, татвар, НДШ болон бусад хуримтлагдсан өр төлбөрийг үе шаттай барагдуулах, компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцууллаа.

Монгол Улсын хэмжээнд 2024 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 11.6 тэрбум квт цаг цахилгаан эрчим хүч боловсруулж, 10.1 тэрбум квт цаг цахилгаан эрчим хүч түгээсэн. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт өмнөх оны мөн үеэс гүйцэтгэлээр 5.6 хувь буюу 616.8 сая квт цагаар, батлагдсан төлөвлөгөөнөөс 0.04 хувь буюу 4.5 сая квт цагаар тус тус өссөн. Харин цахилгаан эрчим хүчний түгээлт өмнөх оны мөн үеэс 50.9 хувь буюу 592.6 квт цагаар, батлагдсан төлөвлөгөөнөөс 0.23 хувь буюу 23.9 сая квт цагаар тус тус өслөө.

Нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний 73 хувь буюу 8.7 тэрбум киловатт цагийг дотоодын эх үүсвэрээс 27 хувь буюу 2.8 тэрбум квт цагийг импортоор хангасан.

2023-24 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд Сонгино 80мвт-ын хүчин хүчин чадалтай батарей хуримтлуур, Амгалан дулааны станцыг 116мвтын хүчин чадалтай 1 зуухаар шинээр суурилуулах төсөл, арга арга хэмжээг ашиглалтад оруулсан бол 2024-25 оны өвлийн ачаалалд Чойбалсангийн дулаан цахилгаан станцыг 5мвт-аар өргөтгөх төслийг 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 2024 оны 12 дугаар сар болон 2025 оны 1 дүгээр саруудад өвлийн хэт их ачааллын горим ажиллагаа нь нийтдээ 348мвт-ын эх үүсвэрийн чадлыг нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

Дорнод бүсийн эрчим хүчний системээс хангах 50мвт, Эрдэнэ батарей хуримтлуур 20мвт, Багануур батарей хуримтлуур 50мвт, Бөөрөлжүүтийн цахилгаан станцаас 150мвт, Тосонгийн ДЦС-аас 18мвт, Өмнөд бүсийг Өвөр Монголын эрчим хүчний системээс хангах 60мв болно.

Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний эх үүсвэрүүд бүрэн чадлаараа ажиллаж байгаа бөгөөд аль тоноглолд гэмтэл саатал гарах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн үйлдвэрлэл буурах, мөн дээрх эх үүсвэрийн төслүүд төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орохгүй тохиолдолд хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хязгаарлах нөхцөл байдал үүсэхээр байна. Эх үүсвэрийн хүчин

чадлын дутагдал үүсэх үед хөнгөлөлт болон хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, холбогдох зохион байгуулалт, арга хэмжээг авч ажиллаж байна.

Хөнгөлөлтийн хөтөлбөрт нийт 365.5мвт-ын ачаалал бүхий хэрэглэгчдэдээ урьдчилан тохиролцсоны дагуу 17-21 цагийн хооронд 100.3 мвт-ын хүртэл ачааллыг бууруулахаар төлөвлөсөн. Хязгаарлалтын хөтөлбөрийг Улаанбаатар хотод 11, орон нутагт 3, нийт 14 багцад хуваан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Илтгэж дууслаа. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Чойжилсүрэн сайдад баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Хэлэлцэх асуудалтай холбоотой ирсэн И.Лувсанцэрэн Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Г.Энхтүвшин тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Товуудорж Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч, Б.Эрдэнэбулган Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга, Г.Балжинням Диспетчерийн үндэсний төв ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Д.Батзориг Эрчим хүчний яамны Цахилгааны хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүн ирсэн байна.

Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

С.Цэнгүүн, Соронзонболд гишүүнийг нэмээрэй. Соронзонболд гишүүнээр, Жаргалан гишүүнийг нэмье. Ингээд Жаргалан гишүүнээр нэрсийг тасаллаа. Ингээд Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Танилцуулгыг сонслоо. 8 асуулт байна.

Нэгдүгээрт нь цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг ер нь барих байршлын судалгааг эрэмбэлж гаргасан зүйл улсын хэмжээнд байгаа юу? Өөрөөр хэлбэл, дотоодын жишээлбэл нийслэл, төв суурин газрыг хангах. Нэг. Хоёрдугаарт нь экспортод чиглэсэн талаар ямар бодлого барьж байгаа вэ? Тухайлбал, Зүүн бүс, Өмнөд бүс тэр чигтээ эрчим хүчний нүүрсний их нөөцтэй. Өмнөд хөрш хэрэглэгч талдаа экспортлох ийм цаашдын төлөвөө яаж тооцож байгаа вэ? Энэ дундаас тусгайлаад Зүүн бүсийн хувьд ямар төлөвлөлт байна гэдгийг.

Хоёрдугаарт нь Чойбалсангийн ДЦС-ыг 50мвт-аар өргөтгөсөн. Тэгээд энэний онцлог дөрөвний гурвыг нь иргэн төлөлтийг нь станц өөрөө төлнө гэсэн ийм нөхцөлтэй. Тэгээд яг үүн шиг ийм аргачлалаар, ийм нөхцөлтэйгөөр станцуудыг нэмж баривал ямар вэ? Зөвхөн улсын төсвөөс зээлээр барихаасаа гадна ялангуяа уул уурхайн бүс нутагт тариф илүү өндөр байдаг учраас иргэн ийм ашигтай, улсын төсөвт бага дарамттай байдлаар. Энэ дээр асуулт байна.

Дараагийнх нь өндөр хүчдэлийн шугамын ялангуяа 290 шугамыг ямар эрэмбээр байгуулахаар төлөвлөж байгаа вэ? Тухайлбал, олон жил Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаад хэрэгжихгүй яваад байгаа Багануур, Өндөрхаан, Чойбалсан гээд. Яагаад гэхээр байдал дээр 110-ын шугамаар Чойбалсан хотоос ДЦС-аас Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт, Баруун-Уртаас Өндөрхаан гээд ингэж тойрч Хэнтий аймгийг хангаж байгаа.

Гэтэл Хэнтий аймаг маань өөрөө Төвийн бүсээс импортын эрчим хүч нь явсаар байгаад Чойроор дамжаад ингээд Өндөрхаан гээд 110-ын шугамаар явж байгаа учраас энэ маш их алдагдалтай учраас Хэнтий аймгийн хэмжээнд бүхэлдээ, Сүхбаатар аймгийн хэмжээнд бүхэлдээ цахилгаан эрчим хүчний чадлын дутагдал маш их ороод байгаа юм.

Тийм учраас энэ Зүүн бүс нутгийн хөгжил дээр энэ их томоохон гол шугам учраас энэ магистрал шугам буюу Багануур, Өндөрхаан, Чойбалсан чиглэлийн шугамыг яаж хэрэгжүүлэх вэ? Гаднын зэл, тусламжаар уу, эсвэл ямар зүйл төлөвлөж байна? Ингэх юм бол Зүүн бүсийн 50мвт-ын цахилгаан станцтай энэ маань холбогдох боломжтой болно.

Нисэх онгоцны буудал шинээр барих болон метро, хурдны галт тэрэг барих зэрэг газрууд эрчим хүчний хамгийн багадаа 3-аас доошгүй эх үүсвэр хэрэгтэй. Яагаад гэвэл метро гэдэг чинь далд байдаг. Аюулгүй ажиллагааны хувьд эх 1 үүсвэртэй байх ямар ч боломжгүй. Энэ хүний амь нас далд байдаг учраас винтилятор гээд олон зүйлүүд байдаг учраас энэ зүйл дээр ер нь яаж төлөвлөж байгаа вэ? Энэ хамгийн чухал манай эрчим хүчний салбарын хөгжлийг тэтгэх чухал зүйл учраас бид нар метро барина гээд байдаг, хурдны галт тэрэг барина гээд байдаг, нисэх онгоцны буудал барина гээд байдаг эрчим хүчний найдвартай 3-аас доошгүй эх үүсвэрийг ер нь яаж тооцож байгаа вэ?

Дараагийнх нь хилийн боомтуудыг эрчим хүчинд холбох талаар ер нь ямар бодлого барьж байгаа вэ? Энэ бол ялангуяа энэ.../минут дуусав./

Р.Сэддорж: Бадамсүрэнд гишүүн 1 минут нэмье.

М.Бадамсүрэн: Дараагийнх нь 7 дахь нь төв суурин газарт ингээд дулааны шугам татаж байна. Гэхдээ энэ дээр манай Эрчим хүчний яамны зүгээс энэ дээр дүгнэлт хийсэн зүйл байгаа юу? Зарим аймгийн төв дээр энэ зүйлүүд маань бас хүндрэлтэй асуудал үүссэн. Өөрөөр хэлбэл, айлын гудмаар шугам явдаг ч гэсэн гэр рүүгээ татахад хамгийн багадаа 30 сая төгрөг. Тэгэхээр энийг ер нь яаж шийдвэл зөв гэж үзэж байгаа вэ? Бие даасан бохирын байгууламж, бие даасан ийм эрчим хүчний эх үүсвэрүүд, дулааны эх үүсвэрүүд тал дээр ер нь ямар бодлого барих вэ? Жишээлбэл, нийслэлд газын халаалтад зарим хэсгийг шилжүүлнэ ээ гэж байна. Ихэнх улс орнуудад газ болон цахилгааны бай юугаар хангадаг. Манай нөхцөлд яаж энэ дээр ийм тооцоо байна уу?

Энэ зүйлүүд дээр тодорхой хариултуудыг бас авмаар байна. Яагаад гэвэл энэ эрчим хүчнийхээ энэ төлөвлөлтийг том хөгжлийн бодлоготойгоо уялдуулж явах нь өөрөө хамгийн зөв бодлого болно. Тэгэхгүй бол ийм салангид явж ерөөсөө.../минут дуусав./

Р.Сэддорж: Ажлын хэсгээс хариулъя. 8 асуулт асуусан. 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Зарим асуултыг чинь бас бичиж авч амжсангүй бол уучлаарай. Нөхөөд асуу.

Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүдийг яаж эрэмбэлж байгаа юм бэ гэж байна. Бид нар Төвийн бүс, Зүүн бүс, Баруун бүс, Алтай, Улиастайн эрчим хүчний систем гэсэн Монгол Улс 4 эрчим хүчний системтэй.

Төвийн бүс дээр бол 6 ДЦС холбоотой байгаа. Сая би тэрийг танилцуулгадаа дурдсан. 311мвт-ын 8 нарны станц, 3 салхины станц холбоотой байгаа. Ийм асуудлууд бий.

2027 оны 6 сарын 30 гэхэд Монгол Улс Төвийн бүсдээ ямар ч байсан хэрэглээгээ даваад гүйцчих болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Бөөрөлжүүтийн цахилгаан 600мвт-ын цахилгаан станцыг 27 онд, энэ жил 105мвт-ын 1 блокыг ашиглалтад авна. Ирэх жилийн 12 сарын 1 гэхэд 2 дахь блокыг ашиглалтад авна. 27, 28 онуудад 3, 4 дүгээр блокуудыг ашиглалтад авах юм. Баянгийн цахилгаа станц 660мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц баригдаад эхэлсэн. 2027 оны наадам гэхэд ашиглалтад оруулахаар ийм төлөвлөгөөтэй яваад ажил нь бол хэвийн үргэлжилж байгаа ийм байдалтай явж байгаа юм.

Тэгэхээр бидний хувьд нэг хүндрэлтэй зүйл байгаа нь энэ цахилгаан эрчим хүчний хэрэглээний дийлэнх нь Улаанбаатар хот байгаа, хэрэглээ үүсчхээд байгаа юм. Тэгэхээр энэ Монгол саяын миний дээр дурдсан юу станцуудыг үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хотод оруулж хэрэглэгчдэд хүргэхэд бол тодорхой хэмжээний бэрхшээл байна. Манай Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төвөөс хамтарсан ажлын хэсэг бид нар судалгаа хийгээд явж байгаа. Ямар ч байсан энэ ондоо багтаагаад бид нар холбогдох цахилгаан дамжуулах агаарын шугам хуваарилах байгууламжуудыг ашиглалтад оруулна гэсэн ийм тооцоололтой явж байгаа юм. Зүүн бүсийн эрчим тухайд 50мвт-ын ДЦС ашиглалтад орсон байгаа. Одоо энэ бид нарт ирж байгаа мэдээллээр бол энэ хуучин 36 байж байгаад 50-ыг нэмээд 86мвт-ын хүчин чадалтай болж байгаа. Ерөнхийдөө энэ техникийн нөхцөл өгсчхөөд байгаа боловчиг ойрын 2, 3 жилдээ бол Зүүн бүсэд шинээр гарч ирэх цахилгаан эрчим хүчний хэрэглээг бол хангачих юм байна лээ. Цаашид бол дахиад Дорнод бүс дээр бол магадгүй 100мвт-ын цахилгааны станцыг барих талаар бол холбогдох судалгаануудыг хийгээд явж байгаа иймэрхүү байдалтай явж байгаа юм.

Таны хэлж байгаа үнэн тэр Дорнод бүсээс бид нар энд Сүхбаатараар дамжуулаад Хэнтий аймгийг холбоход бол тодорхой хэмжээний 110-ын шугамтай учраас тодорхой хэмжээний шугамын алдагдалтай өндөр хүчдэл унадаг ийм хүндрэлүүд бий. Мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бол Багануур-Өндөрхаан-Чойбалсан гэдэг 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын хос шугамыг барьж байгуулна гэсэн ийм зорилт тусгаад явж байгаа. Энэ талаар бид нар Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк тэргүүдтэй манай улстай хамтарч ажилладаг, уламжлалт хамтарч ажилладаг энэ донор байгууллагуудад санал, хүсэлтийг нь тавиад явж байгаа ийм байдалтай байгаа.

Таны хэлж байгаа тэр Дорнод бүс дээр бол энэ Дорнодын 50мвт-ын цахилгаан станц 80 орчим сая доллароор босож байгаа. Үүний 75 хувийг нь бол Хятадын Хөгжлийн банк санхүүжүүлж байгаа. Манай Монголын Хөгжлийн банк үүнийг дамжуулан санхүүжүүлж байгаа 25 хувийг нь төсөлд нь төлөхөөр ийм тооцоолол хийсэн. Энийг хийхийн тулд Дорнодын цахилгаан станцаасаа Дорнод бүсийн эрчим хүчний систем рүү нийлүүлэх тарифыг бол ойрын жилүүдэд энэ төслийг төлж дуустал бол бид нар тодорхой хэмжээнд өндөр тариф баталж байж

энэ төслийг бол тэгээд ямар ч бай үр ашигтай болгоод ашиглалтад оруулахаар ийм тооцооллууд хийгээд явж байгаа гэдгийг л хэлье.

Энэ метро болон энэ бусад метро, нисэх, нисэх буудал гээд энийг бол яг тэр төсөл хэрэгжүүлэх гэж байгаа. Захиалагч байгууллагуудад бол ямар хэмжээний.../минут дуусав./

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайдад нэмэлт цаг өгье.

Б.Чойжилсүрэн: Ямар эх үүсвэрээс хэдэн эх үүсвэртэй байх юм, ямар чадалтай байх юм гэдгээ захиалагч байгууллагууд манай эрчим хүчний салбарт хүсэлтээ ирүүлсний дараа бид нар тухай бүр нь газар дээр нь шийдээд явж байгаа ийм зүйл. Би энийг одоо бол манай яаман дээр метро, нисэх буудал зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа учраас эдгээр захиалагч байгууллагуудаас ирсэн хүсэлтийнх нь дагуу техникийн нөхцөлийг нь гаргаж өгч байгаа.

Хилийн боомтуудыг цахилгаан эрчим хүчинд холбох ямар бодлого барьж байна гэж байна. Ерөнхийдөө бол боломжоор нь бид нар ингээд боомтуудыг бол цахилгаан эрчим хүчинд холбож байгаа. Сүхбаатар аймгийн тухайд Бичигтийн боомтыг БНХАУ-аас 1 компани цахилгаан эрчим хүч 110-ын шугамаар цахилгаан эрчим хүч импортольё гэдэг ийм хүсэлтийг тавьсан. Бид бодлогын хувьд дэмжээд явж байгаа иймэрхүү байдалтай байгаа юм.

Энэ төв суурин газар дулааны шугам тавьж байна гэж ярьж байна. Энэ бид нар энэ хуучин манайх шиг ийм хүйтэн улс оронд бол.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Энэ дулааны шугамаа бид нар нүүрсээ шатаахаас ондоо дулаан гаргахад бол ийм эх үүсвэр алга байна. Танд жишээ болгоод хэлэхэд манай Амгалан дулааны станцын, дулааны станц шүү цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхгүй байгаа. 1 гега килокалори цагийн өртөг нь 95 мянга орчим төгрөг байгаа. Сэлбэ дэд төвийн өөрийнх нь өртөг 125 мянга орчим төгрөг байгаа.

III, IV дүгээр цахилгаан станцаас бид нар бол төвийн бүсэд нийлүүлэхдээ өөрийнх нийлүүлж байгаа өртөг нь 65 мянга, 66 мянга орчим төгрөгийн үнэтэй байна. Газаар дулаан үйлдвэрлэсэн тохиолдолд бол 1 гега килокалори цаг нь 350 мянга төгрөгийн үнэтэй босож ирэхээр ийм л тооцоо гараад байгаа юм.

Р.Сэддорж: Өөр хариулах хүн байна уу бусад асуултууд? Айн? Бадамсүрэн гишүүн хариулт тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Эрчим хүчний сайд аа Хэнтий аймгаас ямар хүсэлтүүд их ирээд байна гэхээр ерөөсөө эрчим хүчний маш их дутагдалд байна. Зүүн бүсэд ингээд Чойбалсангийн ДЦС 80, 100мвт болчихсон. Тэгээд тэндээс эрчим хүчээ авъя гэхээр ингээд хангаж өгөхгүй байна гэдэг энэ асуудал их ирээд байгаа. Ер нь ингээд цаашдаа нөгөө бүс нутгийн хөгжил гэдэг маань өөрөө аль болох бие даалгах. Тийм учраас энэ Хэнтий аймгийг, төвийг Чойбалсангийн станцаасаа энэ Сүхбаатараар дамжсан 110-ын шугамаар хангах ажлыг төвийн тэр Баянгийн станц ашиглалтад ортол энэ эх үүсвэр нэмэгдэл шийдэхгүй бол энэ их хүндрэлтэй асуудал үүсээд байгаа юм. Тэгээд энэ дээр яг би тодорхой хариулт авмаар байна. Энэ талаар бас холбогдох эрчим хүчний станцууд дээр яаж зохицуулалт хийх юм,

энэ дээр өгсөн чиглэл байгаа юу? Сайдын бодлогын хувьд ямар бодлого барьж байгаа вэ? Зүүн бүсээс сонгогдсон гишүүнийхээ хувьд энэ зүйл дээр анхаарал хандуулахгүй бол маш их дутагдал.../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер хариулт.

Б.Чойжилсүрэн: Тийм ээ Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Бид нар энэ өвөл оргил ачааллын цагаар чадлын дутагдалд орчхоод байгаа юм. Тийм учраас таны ярьж байгаагаар Дорнодыг тусад нь бүхлээр нь Дорнодын цахилгаан станцаас, Сүхбаатар аймгийг бүхэлд нь Дорнодын цахилгаан станцаас, Хэнтий аймгийн холбогдох манай хэдэн сум байгаа билээ? Хэнтий аймгийн 3 сумыг цаад талаасаа, бид нар төвөөсөө өгдөг байсан хангадаг байсныгаа энэ жил цаанаасаа аваад төвдөө бас 30 мвт суллаж авч байгаа ийм тооцооллууд бий. Эх үүсвэрийн дутагдалтай байгаа учраас ийм хүндрэлүүд явна. Наад асуудлууд чинь хэзээ шийдэж дуусах вэ гэхлээр Баянгийн цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц ашиглалтад орсны дараа Багануур Өндөрхааны 220 киловольтын шугам барьсан тохиолдолд бүрэн шийдэгдэнэ. Энэ болтол тодорхой хэмжээний бэрхшээл байна.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Сайн байна уу? Эрчим хүчний яамныхандаа баярлалаа мэдээлэл өгч байгаад.

Тэгээд бид нарт урьдчилан тараасан мэдээлэл дээр болохлоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 5325 мвт цахилгаан эрчим хүчний, 1778 мвт дулааны эрчим хүчний, экспортын зориулалттай 5000 мвт цахилгаан эрчим хүчний чадал бүхий нийт 35 эх үүсвэрийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлүүлэхээр зорилт дэвшүүлсэн гэсэн ийм өгүүлбэр байна л даа. Тэгэхээр Монголын эрчим хүчний салбарт яах аргагүй хөрөнгө оруулалт, шинэ төслүүд хэрэгтэй нь гарцаагүй.

Гэхдээ нэгэн зэрэг ийм маш олон ийм төсөл, хөтөлбөрүүдийг эхлэхлээр цаашид зарим нь гацах юм уу, эсвэл царцах, эсвэл зогсох тийм эрсдэлүүд байгаа гэж харагдаад байна. Тэгэхээр яг энэ яамны бодлого дээр энэ эрэмбэлж байгаа явдал байна уу? Яг одоогоор энэ тараагдаад өгчихсөн материал дээр ингээд бараг маш олон төслүүдийн жагсаалтыг ингээд ямар ч эрэмбэ, дэс дараагүйгээр ингээд оруулчихсан харагдаж байна л даа. Тэгэхээр угаасаа эдийн засгийн багтаамж гэж бий, бид нарын дотоодын хэрэглээ хэдийгээр жил болгон 5, 6 хувь нэмэгдээд байгаа боловчиг дотоодын хэрэглээ ингээд ойлгомжтой, экспорт руу гаргахад бас тодорхой өөр учир шалтгаанууд байгаа.

Тэгэхээр энэ нэгэн зэрэг ийм олон төсөл, хөтөлбөрүүд эхлүүлж байгаа нь бас ямар эрсдэл дагуулж байна вэ гэдэг дээр хариулт авмаар байгаа юм. Уул нь жишээлбэл хамгийн ойлгомжтой, худалдан авагч нь тодорхой, хөрөнгө оруулалт нь ч гэсэндээ ойлгомжтой төсөл бол Тавантолгойн цахилгаан станц шүү дээ.

Гэтэл нөгөө Тавантолгойн цахилгаан станц маань шүүхийн асуудлын улмаас ингээд тодорхойгүй хугацаагаар ингээд зогсчоод байгаа гэж ойлгоод байгаа. Тэгээд ер нь энэ тендертэй нь холбоотой яг ямар маргаан гарчихсан юм бэ? Яагаад энэ нь шийдэгдэхгүй байгаад байгаа юм бэ? Бид нар яг ийм бодитой

явуулж чадах төслүүдээ явуулахгүй байгаа хэр нь ингээд ийм бас ийм мөрөөдлийн жагсаалт шиг бас баахан ийм төсөл жагсаачхаад сууж байна л даа.

Хоёрдугаарт нь Бөөрөлжүүтийн цахилгаан станц ингээд ашиглалтад орж байна гэж байна. Бөөрөлжүүт дээр болохлоор нийслэлийн гаргасан бондоос санхүүжилт олгосон гэж ойлгоод байгаа. Одоо энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц дээр хувь эзэмшиж байгаа явдал байна уу? Нийслэл юм уу, улс юм уу тээ? Ер нь энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын хувь эзэмшигч нь хэн бэ? Тэр нөгөө санхүүжилт олгосон яг тэр гэрээ нь яг ямар нөхцөлтэй гэрээ байсан бэ? Мөн хэзээнээс яг нийлүүлэлтээ эхлэх юм, яг хэдэн төгрөгөөр худалдаж авах юм бэ эрчим хүчээ гэдэг асуулт байна.

Гуравдугаарт, нь энэ Эрчим хүчний яамнаас ийм мэдээллүүд орж ирж байгаад байгаад байгаа хэр нь Улаанбаатар хот, нийслэлийн засаг захиргаа, нийслэлийн удирдлага болохлоор дулааны бас 5 дугаар цахилгаан станц гээд бас шал өөр юм сүүлийн өдрүүдэд яриад байна. Тэгэхээр ийм нэгдсэн бодлого явж байгаа юм уу, эсвэл нийслэл нь ингээд шал тусдаа бас ийм төсөл, хөтөлбөрүүд бас эхлүүлээд байгаа юм уу? Сэдээ даргаа минутаа нэмээд авчихъя тэгэх үү?

Р.Сэддорж: Жаргалан гишүүн нэмээд.

Б.Жаргалан: Эх үүсвэрүүдтэй холбоотой ийм асуултууд байна. Сүүлийн энэ хүйтний улирал эхэлснээс хойш агаарын бохирдол, утаа огцом нэмэгдсэн асуудал дээр нийгэм даяараа санаа зовниж байна. Тэгэхээр энэ асуудал болохлоор энэ цахилгааны үнэ, тариф нэмэгдсэнтэй холбоотой хэрэглээн дээр өөрчлөлт гарсантай ямар нэгэн байдлаар холбоо байна уу? Гэр хорооллын айл өрхүүд халаагуур ашиглахаасаа илүүтэй нүүрс түлж эхэлж байна уу? Энэ нь ямарваа нэгэн нөлөө үзүүлж байгаа тал дээр танай яам судалгаа хийж байна уу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, сая бас Улаанбаатар хот даяар цахилгааны хязгаарлалтууд нэлээн явлаа л даа. Тэгэхээр цаашид энэ өвөл бид нар хэр их ийм цахилгааны хязгаарлалт доор амьдрах вэ? Энийгээ урьдчилан зарлах боломж бий юү? Ийм асуу асуултууд байна. Эх үүсвэртэй холбоотой хэдэн асуултууд, тэгээд энэ өвлийн бэлтгэл ажилтай холбоотой асуултууд.

Р.Сэддорж: Хариулт Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Жаргалан гишүүн бас юу зөв логиктой асуулт асууж байгаа юм.

Яг өнөөдрийн байдлаар бид нар яг төвийн бүсдээ бид нар чинь 1264мвт-ын суурилагдсан хүчин чадалтай 6 дулааны станцтай улсууд шүү дээ. Дээр нь 311мвт-ын сэргээгдэх эрчим хүч холбогдчихсон ийм байгаа юм. Тэгэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бол 5325мвт-ын цахилгаан эрчим хүчний эх үүсвэр, 1778мвт-ын дулааны эх үүсвэр барина гэдэг ийм зүйл орсон. Одоо Их Хурал дээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлах онцгой бүрэн эрх нь Их Хурлын гишүүдэд байгаа байхгүй юу. Зарим саналууд нь Их Хурал дээр нэмэгдсэн юмнууд бий.

Гэхдээ бас тодорхой хэмжээний хүндрэлийг бас ойлгоорой. Энэ төсөл манай тухайд 2015 оны Парисын хэлэлцээрээс хойш барууны улс орнууд нүүрсний

төслүүдийг, станц төслүүдийг санхүүжүүлэхгүй байгаа. Санхүүгийн байгууллагууд нь санхүүжүүлэхгүй байгаа. Одоо бүр хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй листэд компаниуд нь нүүрсний төсөл, тоног төхөөрөмж үйлдвэрлэж нийлүүлэхгүй ийм хүндрэлтэй түүнээс болсон.

Түүнээс гадна 2021 онд энэ Хятад Улсын дарга Ши Жиньпин дарга НҮБ-ын 173 дугаар чуулган байх, уучлаарай нэр андуурсан бол, энэ чуулган дээр Хятад Улсын газар нутгаас гадна цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдэг ийм амлалтыг дэлхийн олон нийтийн өмнө улс төрийн амлалт авчихсан. Хятадын төрийн шийдвэрүүд гарчихсан учраас энэ нүүрсний төслүүд дээр бол санхүүг татах бололцоо бол 15 оны өмнөх үеэсээ харьцуулахад бараг 10, 15 дахин буучихсан ийм байгаа юм.

Тийм учраас одоохондоо бид нар ямар ч байсан байгаа эх үүсвэрээсээ илүү хамаагүй хөөцөлдөөд явж байна. Бүтсэн нь, түрүүлээд бүтсэн тохиолдолд бол дараагийн нөхдүүдийг нь бол бид нар эсвэл төслөө жоохон хүлээх, эсвэл экспортын гарц олж энэ үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг нь бол борлуулах тал дээр туслахаар ийм тооцооллууд хийгээд явж байгаа гэдгийг танд хэлье.

Хоёрдугаарт, Тавагтолгойн ДЦС-ын тухайд бол тендер зарлагдсан. EPC+F гэдэг нөхцөл 30 хувийг нь бол “Эрдэнэс Тавантолгой” компани санхүүжүүлнэ, 70 хувийг нь EPC контрактор нь санхүүжилтээ цуг олж орж ирэхээр ийм нөхцөлтэй тендер зарлагдсан. 2023 оны 7 сарын 27-ны өдөр байх 2 компани тендерт ороод түүнээс хойш 2 компанийн хооронд маргаан үүсэж явсаар байгаад харамсалтай нь энэ өнөөдрийг хүртэл энэ төсөл маань хэрэгжиж чадаагүй ийм харамсмаар зүйл болж байгаа нь үнэн.

Энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын хөрөнгө оруулагч нь бол Монголын “Бодь интернэйшнл” гэдэг компани 100 хувь эзэмшиж байгаа. Нийслэлээс бол 300 тэрбум төгрөгийн бонд босгоод энэ станцад санхүүгийн эх үүсвэр дутагдаж байгаа учраас хувь эзэмшихгүйгээр зүгээр зээлүүлчхэж байгаа юм. Энэ ашиглалтад, энэ өвлийн оргил ачаалалд ашиглалтад оруулахын тулд Нийслэлийн Засаг дарга бас эрчим хүчний салбарыг бол дэмжье, бид нар ямар ч байсан энэ нийслэлийн хэрэглэгч нараа бага цахилгаан хязгаарлая гэдэг ийм бодлогын хүрээнд 150мвт-ын 1 дүгээр блокийг ашиглалтад оруулахад 300 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлсэн юм. Өөрийнхөө бонд босгосон хүү байгаа шүү дээ. Тэн дээрээ хувь 1 гэл үү, 2 хувь гэл үү бас нөгөө юуныхаа зардлыг бас суулгаад ийм байдалтай явж байгаа. Тэгээд 3 жилийн дотор буцаагаад төлөх нөхцөлтэй байх. Энэ талаар бол нийслэл илүү тодорхой хариулт өгөх болов уу гэж бодож байна.

V дугаар цахилгаан станцын тухайд бол II дугаар цахилгаан станцын үнсэн сан дээр нь 300мвт-ын цахилгаан, 395мвт-ын дулааны станц байхаар бид нар манай Эрчим хүчний яам бид нар тооцоо, ТЭЗҮГ-г хийчихсэн юм. Тэгээд энэ төслийг бид нар нийслэлд шилжүүлж өгч байгаа. Яагаад нийслэлд шилжүүлж байна вэ гэхлээр 40 орчим хувийг нь экюти/equity/ буюу заавал нийслэлийн төсвөөр суулгаад 60 орчим хувь дээр нь EPC+F гэдэг нөхцөлөөр тендер зарлахын тулд
.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулья 4 номер.

Б.Чойжилсүрэн: Санхүүжилтээ босгоход дан ганц улсын төсөв гэхээсээ түрүүлээд нийслэл, орон нутгийн төсвийг дайчилъя гэдэг ийм байдлаар хоттой ойлголцоод явж байгаа. Нэгэнт хот руу энэ тендерийг нь зарлах эрхийг нь шилжүүлж байгаа учраас би одоо янз бүрийн юм ярихгүй байгаа. Гэхдээ Эрчим хүчний яам хот хоёр бол энэ дээр ямар нэгэн санал бодол зөрүүлэхгүй, нягт хамтарч ажиллаж байгаа. Бид нар бүх холбогдох дэмжлэгүүдийг үзүүлнэ.

Энэ утаатай холбоотой асуудлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга хариуцсан “Тавантолгой түлш” компанийг бол нийслэл рүү шилжүүлсэн учраас бид нарт ярих юм алга байна.

Танаас асуусан цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдээд цахилгаан халаалтуудаасаа татгалзаж байгаа ийм судалгаа байна уу гэж асууж байна. Ерөнхийдөө бид нар тийм айхтар хотыг дамнасан хэмжээний, өргөн хэмжээний судалгааг хийгээгүй. Баримжаалаад үзэхэд сүртэй тийм өөрчлөлтүүд гарахгүй байгаа.

Р.Сэддорж: Өөр бас хариулах хүн байна уу? Бөөрөлжүүтийн хувь, хувьцааны асуудлууд. Нэмж хариулъя 4 номер.

Б.Чойжилсүрэн: Жаргалан гишүүний 1 асуултад дутуу хариулсан байна. Энэ хязгаарлалтын талаар.

Яагаад хязгаарлалт хийж ч магадгүй, хийхгүй ч байж магадгүй гээд байгаа юм. Нөгөө нарны, салхин станц байгаа шүү дээ 150 мвт-ы 3 станц байгаа. Тэр үед салхитай байгаад байх юм бол бид нар хязгаарлалт хийхгүй, салхи орж ирэхгүй бол бид нар тодорхой хэмжээнд хязгаарлалт хийхээс ондоо аргагүй ийм байдал үүсчхээд байгаа юм.

Р.Сэддорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ 3 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт ингээд утааны нөхцөл байдлыг харахаар бид энэ шахмал түлш хэрэглэдгээ хэзээ нэгэн цагт болих байх гэж найдаж байгаа. Тэгэхээр тэр болих үед мэдээж цахилгаанаар халаалтаа шийдэх асуудал гарч ирнэ. Тэгвэл өнөөдөр гэр хороололд байгаа нийт дэд станц, дамжуулах, түгээх станцуудын хүчин чадал нь хүрэлцэхгүй байгаа нь нийт тооныхоо хэдэн хувьд нь хүрэлцэхгүй байдаг юм бэ? Энийг хүчин чадлыг нь нэмэх талаар судалгаа хийсэн юм байдаг уу? Хэрвээ шаардлагатай бол энд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа гэж харж байгаа вэ гээд ийм асуулт байгаад байгаа юм.

Тэгээд сүүлийн үед болохоороо зөвхөн Улаанбаатар гэхгүй орон нутагт ч гэсэндээ бас цахилгааны хэлбэлзэл их байна. Айл өрхийн цахилгаан бараа их шатаж байна, цахилгааны хязгаарлалт хийснээс болоод хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа чадахгүй байна гэсэн гомдлууд бас ирж байна л даа. Тэгэхээр ер нь улсын хэмжээнд энэ байдал ямар байдаг вэ гэдэг талаар ийм албан бичгээр хариу өгчихвөл их зүгээр байна. Харин утааны асуудал дээр эхлээд хариултаа авчихъя гэж бодож байна.

Хоёр дахь асуулт маань болохоор энэ түгээх, дамжуулах энэ шугамыг миний ойлгосноор стандартын бусаар хол зайд бас хэтэрхий их барьж байгаа

асуудал байдаг юм байна гэж ойлгосон. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор болохоор энэ цахилгааны өртөгт энэ стандарт бус зайд дамжуулах, түгээх шугамыг барьсантай холбоотойгоор өртөг өсдөг юм байна. Тэгэхээр иргэд дээр очиж байгаа цахилгааны өртгийн хэдэн хувь нь энэ стандарт бус зайнд барьснаас болж бий болж байна вэ гэдэг ийм асуулт байгаад байгаа.

Дараагийн асуудал болохоор энэ олон улсын судалгаанаас харахад энэ нар, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өртөг их буурч байна. гэж ярьж байгаа. Тэгээд танайхаас өгсөн мэдээллийг харахаар та хэдийн хийсэн гэрээ болохоор ер нь нарны цахилгаан станцын үйлдвэрлэлийн өртөг олон улсын хэмжээнд 5 цент, салхин станцынх нь 3 цент байхад та хэдийн хийж байгаа гэрээ болохоор дандаа тэрнээс 3 дахин илүү өртөгтэй ийм байгаад байгаа. Энэ нь болохоор мэдээж тухайн станцуудыг барьж эхэлсэн хөрөнгө оруулсан хугацаатай холбоотой гэдгийг нь ойлгож байна.

Тэгэхдээ хэзээнээс бид нар энэ олон улсын жишиг үнэ рүү ойртсон гэрээг барьж эхлэх юм бэ? Өнөөдөр хийж байгаа гэрээ маань ер нь дунджаар ямар хугацаатай хийгдээд байгаа юм бэ гэсэн ийм асуултууд байна. Тэгэхгүй бол бид нар маань баахан урт хугацаатай гэрээ хийчихдэг, тэгээд улсаас зайлшгүй тэрийг нь төлдөг ийм байдалд ороод ийм баахан алдагдалтай систем рүү шилжиж байгаа юм биш биз дээ гэдэг ийм асуулт байгаад байгаа.

Дараагийн, сүүлийн асуулт болохоор энэ цахилгаан эрчим хүчний үнийг бид нар үе шаттайгаар нэмж байгаа. Үе шаттайгаар нэмж байгаа. Тэгэхдээ бид нар яг хэзээ бид нар ер нь энэ эрчим хүчний үнийг цаашдаа тогтворжуулаад ер нь цаашдын эрчим хүчний нийлүүлэлт нэмэгдсэнээс болоод ер нь эрчим хүчний өртөг иргэдийн төлж байгаа өртөг буурна гэж харж байгаа вэ гэсэн асуулт байна.

Р.Сэддорж: Хариулья 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулья.

Соронзонболд гишүүн ээ яг ийм шууд тооцоог хийгээд нарийвчилсан ТЭЗҮ гаргачихсан юм алга байна. Гэхдээ нэг ийм байгаа. Улаанбаатар хотын тухайд ярихад 198 мянга гэж ярьдаг, заримдаа 230 мянга гээд бид нар энэ дээрээ бол яг нарийвчилж чадаагүй байгаа, айлууд, гэр хороололд цахилгаан байгаа. Эдгээр айлуудыг дунджаар 8 мвт гээд бодох юм бол зарим томхон 100м²-тай айлууд бол 15 мвт-ын цахилгаан эрчим хүч хэрэглэх юм байна лээ. Яг өвлийн оргил ачааллын үедээ. Ингэхээр 2000 мвт буюу 2 гига орчим цахилгаан эрчим хүчтэй байхад бол Улаанбаатар хотыг цахилгаанаар халаах тухай юу ярьж болох юм. Гэхдээ энэ маань 2 гига маань ойролцоогоор 4 орчим тэрбум доллар болно. Дээр нь нэмээд хуваарилах байгууламжууд, цахилгаан дамжуулах агаарын шугамууд гээд ингэх юм бол Улаанбаатар хотыг бүрэн цахилгаанаар халаах гэж тооцоолоход 7.5, 8 орчим тэрбум доллар хэрэгтэй гэсэн ийм тооцоо, судалгаанууд гардаг юм байна лээ.

Хоёрдугаарт, цахилгаан эрчим хүчээр, цахилгаанаар халаасан тохиолдолд өртөг нь бол нүүрснээс халааснаас бол доор хаяж 3 дахин өндөр үнэтэй болно. Бүх амьдралын өртөг, бүх бизнесийн өртөг энэ хэмжээгээрээ бас нэмэгдэхэд бас бид нар тооцох хэрэгтэй. Үр ашгаа тооцохгүйгээр баахан олон юм гоё юм яриад ард түмэнд буруу хүлээлт өгөөд байхаар их төвөгтэй байгаа учраас үнэнийг нь хэлж байгаа. Үнэнийг нь хэлэхээр заримдаа над руу жоохон дайрч байгаа юмнууд

бий. Өртгөө бид нар тооцохгүй бол манай GPP чинь 20 тэрбум доллар хүрээгүй байгаа шүү одоо. Ийм ярьж байна.

Түгээх дамжуулах дээр стандарт бус шугам сүлжээнүүд гэсэн ийм ойлголт та ярих шиг боллоо. Би энэ дээр яг тодорхой танд мэдэж байгаа зүйл байвал тодруулж бид нар шалгая. Улсын комисс бид нар бол эрчим хүчний сайдын тушаалаар улсын комисс ажиллуулах тушаал гаргадаг. Манай Эрчим хүчний яам улсын комисс хүлээж авахдаа бол бүх стандарт шаардлагыг бол биелүүлсэн нөхцөлд улсын комисс хүлээж авч байгаа ийм байгаа.

Нар, салхины станцын тухай та сая өөрөө ярьж байна. Анх 2006 байх аа, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдахад бол 15 центээр байгуулаад хаячихсан 8 нарны станц, 3 салхин станц байгаа. Би сая хэлсэн салхин станцууд 9.4 центээр, нарны станцууд нь бол бүр 17.3 цент хүртэл ийм өндөр өртөгтэй явж байгаа юм. 19 онд орсон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн өөрчлөлтөөр авагдсан бид нар зарлах ёстой. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр одоогоос 1 сарын өмнө Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Узбекистан Улсад аукцион зохион байгуулсан байна. Тэр үед 100мвт-ын нарны станц 40 хувийн батарейтай хүчин чадлынхаа 4 цаг гаргалгаатай, цэнэглэх хүчин чадал нь 4 дахин өндөр байгаа. Ийм станц 4.65 центээр үнийн санал ирлээ гэдэг ийм мэдээллийг би хамгийн сүүлд хямдарч байгаа ийм байна.

Тийм учраас бид нар энэ үнэ хямдрахыг нэгдүгээрт хүлээж байна.

Хоёрдугаарт, гол асуудал бол тогтвортой эх үүсвэр биш учраас бид нар сэргээгдэх эрчим хүчнийг нар ороод, эсвэл салхи зогсчихсон үед бол бид нар чадал хаа нэг газар нөөцлөх учиртай. Энэ нөөцлөх энэ асуудлаа шийдэж чадахгүй байгаа учраас аукцион зарлаж чадахгүй байгаа ийм байгаа юм. Одоо Европын сэргээн босголтын хөгжлийн банктэй бид нар 2, 3 байршил дээр нийлбэр хүчин чадал нь 400мвт-ын батарейны станц санхүүжүүлээч гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа. Ингэсэн тохиолдолд бол бид нар би саяын ярьсан нөгөө 500 орчим мегаватт хүртэл нар, салхины станцуудыг бол холбох техникийн тооцооллыг Европын сэргээн босголтын хөгжлийн банктэй манай Эрчим хүчний яам хамтраад боловсруулаад явж байгаа юм.

Эх нэгийг нь бол энэ Дундговь Төв аймгийн төв дээр нөгөөдхийг нь Чойр.../минут дуусав./

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ ингэсэн юм. Цахилгаан түгээх дамжуулагч сүлжээн дээр ингээд байгаа байхгүй юу. 35Квт-ын шугам стандартаараа 70км-ийн зайд ч юм уу барих ёстой л юм байна л даа. Хүчин зүйл 100 хувь гаргахын тулд. Тэгэнгүүт миний ойлгосноор бол манайх яг тэгж тэр километрийнхээ зайг барихгүй, 140-200км-ийн зайд ч юм уу барьдаг юм шиг байгаа юм. Тэгэхээр жишээлбэл, шугамын алдагдал ч гэдэг юм уу иймэрхүү асуудал үүсдэг. Тэр нь эргээд бодохоор бас цахилгааныхаа өртөгт тодорхой хэмжээнд нөлөөлдөг юм болов уу л гэж би эдийн засагч хүн бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр талын тооцоо судалгаа хийдэг юм уу л гэж асуусан. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт болохоор нөгөө 4 дүгээр асуулт байгаа шүү дээ тээ? Эрчим эрчим хүчний үнийг бид үе шаттай нэмээд хэзээ бид нар яг ингээд тогтворжоод тэр нь цаашаа явах юм бэ гээд.

Р.Сэддорж: 3 номер Товуудорж дарга.

П.Товуудорж: Дамжуулах, түгээх сүлжээний алдагдал ойролцоогоор 15-20 хувийг нь алдаж байгаа нийлбэрээрээ. Улсын хэмжээнд хамаараад хүчлийнхээ түвшнээс хамаараад янз бүр байгаа. Эрчим хүчний үнийн хувьд энэ удаагийн эрчим хүчний үнэ, тарифын өөрчлөлтөөр 280 төгрөг гэдэг үндсэндээ өртөгтөө хүрсэн гэж үзэж байгаа. Дулааны хувьд ч гэсэн 63 мянган төгрөгт хүрсэн байгаа.

Тэгэхээр цаашдаа ирэх жил эрчим хүчний үнэ, тарифыг бид нар индексжүүлбэ гэдэг индексжих журмаа боловсруулаад явж байгаа. Тэгэхээр индексжих журам маань ямар хүчин зүйлүүдээс явж индексжих вэ гэхлээр хэрэглээний үнийн индекс, валютын ханш, ОХУ-аас импортын үнийн нөлөөлөл, тэгээд Бөөрөлжүүт ч юм уу, сэргээгдэхийн шинэ өндөр үнэтэй эх үүсвэр орчихвол энэ үнийн нөлөөллөөр эрчим хүчний үнэ цаашдаа хөвдөг. Магадгүй валютын ханш буураад хэрэглээний үнийн индекс өсөлтгүй байх юм бол үнэ бас импортын үнэ хэрвээ буурвал, бас буурах хэмжээнд ингэж индексжээд хөвдөг үнийг хэрэгжүүлэхээр зорь.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариултаа нэмж хариулъя. Гүйцээж хариулъя.

П.Товуудорж: Болчихсон.

Р.Сэддорж: Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Гуравхан асуулт байна. Нэгдүгээрт нийслэл хотыг энэ газар дулаанаар хангая. Газрын дулаанаар хангая гэдэг асуудал дээр, дооргүй яригдаж эхэллээ. Танай яамны бодлого яг юу юм бэ? Энийг дэмжиж байгаа юм уу, үгүй юм уу? Энэ боломжтой юу, үгүй юу гэдгийг нэгд хариулж өгөөч ээ гэж байгаа юм.

Хоёрдугаарт, эрчим хүчээр хараат амьдарна гэдэг чинь тийм хөлөө тушуулчихсан тийм адуу шиг л давхиж байя давхиж болохгүй, явъя явж болохгүй тийм болчихоод байна шүү дээ бид нар чинь. Тэгээд Эгийн голын УЦС хэзээ ашиглалтад орох юм бэ? Орох юм уу, бүүр орохгүй юм уу? Бидэнд тэр станцыг барих итгэл найдвар байна уу, үгүй юу? Яг бодит байдал юу байгаа юм бэ гэдгийг хариулж өгөөч ээ гэж.

Гуравт нь Эрчим хүчний зохицуулах хороо гэж юу хийдэг байгууллага юм бэ? Зөвхөн тариф нэмдэг юм уу, зөвхөн тусгай зөвшөөрөл олгодог юм уу? Хэрвээ зөвхөн тариф нэмдэг ажил хийдэг бол энийг чинь заавал байгууллага биш хэдэн эрдэмтэн сууж байгаад ч нэмж болно шүү дээ. Ийм бүтэц хэрэггүй. Тэгэхээр танайх яг юу хийдэг байгууллага юм бэ? Зөвхөн үнэ нэмдэг байгууллага юм уу? Тэрийг яг өөрийнхөө сайдаараа биш өөрөө хариулж өгөөрэй. Ийм 3 асуултыг асууя.

Р.Сэддорж: Хариулт 4 номер сайд.

Б.Чойжилсүрэн: Алдаржавхлан гишүүн ээ ийм байна газар халаа гэдэг ийм тооцоолол хийж байгаа. Өнөөдөр чинь Монгол Улс бид нар яаж байна вэ гэхлээр хийн төлөвтэй газыг шингэрүүлээд тээвэрлэж авчраад буцаад хийн төлөвт оруулаад ашиглаж байгаа. 1гега кил калори цаг газар үйлдүүлсэн эрчим хүчний

дулаан Улаанбаатарт энэ тээврийн зардлуудыг бодоод энэ үнэлгээгээр бодохоор өнөөдрийн байдлаар 350 мянган төгрөг болж байгаа юм. ТЭЦ-2, ТЭЦ-3-аас 1 гега кил калори цаг гээд бид нар сая Товуудорж дарга ярьж байна 65 мянган төгрөг гээд бодохлоор 5-6 дахин үнэтэй ийм л эд. Манай яам дээр бол 116мвт-ын газын эх үүсвэрийг бол энэ барихаар Цэцэрлэгт хүрээлэн дотор газрыг нь авахаар нийслэл өгөхөөр ийм шийдвэр гаргасан. Энэ бол яасан юм гэвэл хэт ачаалагдсан цэгийн өвөлд бол бид нар хөлдөөд хөлдөлт үүсэхгүйн тулд нөөцлөөрөө байдлаар хэт ачаалагдсан шугамуудын төгсгөл дээр холбохоор нэг ийм тооцоолол хийгээд туршилтын ийм төсөл явж байгаа.

Нийслэлээс сүүлийн үед бол газжуулна гэдэг ийм тооцоолол ирсэн. Нийслэлийнхэн маань энэ талаар тооцооллоо дахин та бүхэнд танилцуулах байлгүй. Бид бол ийм л тооцоололтой, ийм мэдээлэлтэй байна газын тухай. Эгийн голын УЦС-ын тухайд манай харамсалтай нь манай гол Эгийн гол маань Сэлэнгэ Мөрөнгөөр дамжаад Байгаль нуур цутгадаг. Та бүхэн мэдэж байгаа. ОХУ-аас ЮНЕСКО-д гомдол гаргасан. ЮНЕСКО-д гомдол гаргасны дараа ЮНЕСКО-гоос манай Монгол Улс ч гишүүн нь юм чинь ЮНЕСКО-гийн гомдлын дагуу бид нар Францын компанийг шалгаруулаад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн. Урьдчилсан дүгнэлтээр бол Эгийн голын УЦС бол Байгаль нуурт сүртэй нөлөөлөл байхгүй гэдэг ийм дүгнэлтийг гаргасан. Энийг би ОХУ-ын Түлш, эрчим хүчний сайд Шульгинов сайд байхад өнөө түрүүчийн сайд руу нь явуулсан. Орост зориулаад ингэдэг найрсаг бус харилцаатай улс орнуудын дүгнэлтийг бид нар хүлээн зөвшөөрмөөргүй байна гээд Оросын Байгаль экологийн яам манай Байгаль орчны яамтай хамтарсан ажлын хэсэг Оросууд Монголын эрдэмтдийн ийм судалгаа дахиж энэ дүгнэлтийг гаргахаар ажиллаж байгаа. Монгол талаасаа бол Одонтуяа сайдын яам оролцоод явж байгаа ийм байдалтай байгаа.

Энэ дүгнэлт гарсны дараа бол бид нар Эгийн гол УЦС-ыг цаашаа яах тухайгаа ярих ийм л нөхцөл байдал үүсэж байгаа. Зохицуулах хорооны талаар Товуудорж дарга.

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

П.Товуудорж: Эрчим хүчний зохицуулах хороо хуулиар Эрчим хүчний хууль, Эрчим хүчний хэмнэлттэй хууль Сэргээгдэх эрчим хүчний хуулийн хүрээнд 4 үндсэн үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг байгаа. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгоно, эрчим хүчний үнэ, тарифыг хэрэглэгч, үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифыг хянаж батална. Хэмнэлтийн хуулийн дагуу эрчим хүчний хэмнэлтийн төрийн бодлогын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дээрээс нь хангагч хэрэглэгчийн хооронд маргааныг шийдвэрлэдэг ийм 4 үндсэн үүрэгтэй. Эрчим хүч маань өөрөө монопол шинж чанартай, тодорхой хэмжээнд нийтлэг олон нийтийн нийтээр хэрэглэдэг учраас тодорхой энэнд олон нийтийн эрх ашгийг хангасан төрийн зохицуулалттай дэлхийд Европын 10 гаруй орноос бусад дэлхийн ихэнх орнуудад ер нь зохицуулалттай эрчим хүчний зохицуулах байгууллагууд үйл ажиллагаа явуулж эрчим хүчний үнэ, тарифыг хангагч, хэрэглэгч хоёроос хараат бусаар хянаж, баталж мөрдүүлэх ийм үүрэгтэй. Тэгэхээр манайд бол ерөнхийдөө эрчим хүчний үнэ, тарифыг 2-3 жилийн тутамд хянаад л батлаад л ингээд л явж байгаа ийм л үүрэгтэй байгууллага байгаа.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Ер нь тэгэхдээ юу яамаар юм биш үү би сайдад бас бодлогын санал тавьчихъя. Энэ Эрчим хүчний үндэсний хороо гээд бас байгаа шүү дээ. Зохицуулах хороо гээд байж байгаа. Тэгэхлээр Барилгын яам чинь тусгай зөвшөөрлийг нь ТББ дээр өгүүлдэг болчихсон юм байна лээ шүү дээ. Удирдаж байгаа юм байна лээ.

Тэгэхлээр Эрчим хүчнийхээ тэр зохицуулах хорооны тэр тусгай зөвшөөрөл энэ тэр эрхийг нь тэр ТББ руу шилжүүлээд, жоохон энэ хүмүүсийн ажлыг хөнгөвчлөөд тийм орчин үеийн жишиг рүү явж болохгүй юу? Би танай байгууллагыг ерөөсөө ойлгодоггүй юм. Тарифын үнэ нэмэх болохоор гарч ирдэг, бусдад алга болчихдог. Тэгээд тусгай зөвшөөрлийнхөө араас явж байгаа юм уу, үгүй юм уу бүү мэд. Хяналт тавьж байгаа юм уу, үгүй юу бүү мэд. Тэрийгээ бусдад ярьдаг ч үгүй, тийм нууц байгууллага байгаад байгаа байхгүй юу. Зөвхөн үнэ нэмэх болохоор гарч ирдэг танайх бол. Тэгэхлээр энэ байгууллагыг өөрчлөн зохион байгуулаад тэр тусгай зөвшөөрөл энэ тэрийг хувийн хэвшилд өгөөд жоохон хөнгөвчилж болохгүй юу? Заавал бид нар ийм олон хүнийг тэжээж ингэж байх шаардлага байна уу, үгүй юу гэсэн зүгээр санал байгаа шүү хариулаад байх шаардлага байхгүй.

Р.Сэддорж: Санал хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдийн гол асуудал болчихоод бид нар чинь бүгдээрээ л эрчим хүчний мэргэжилтэн шахуу болчихсон л нийгмээрээ л үзээд байдаг ийм л нөхцөл байдалтай. Ер нь үндсэн шалтгаан тэгээд тодорхой бас тодорхой шүү дээ. Эрчим хүч улс төрийн арга хэрэгсэл болсон, сонгуулийн арга хэрэгсэл болсон. Сүүлдээ халамжийн арга хэрэгсэл болоод хувирсны л гор гай. Бид нар бүгдээрээ л нэвтрээд л ингээд амсаад сууж байна. Тэгээд сүүлийн үед яригдаж байгаа эрчим хүчний реформ гээд гоё юуг яваад байдаг. Реформ хийнэ, либералчилна, чөлөөлнө гээд. Тэр маань яг сүүлдээ үнэ нэмэх болоод л дуусаж байгаа ч юм уу, үргэлжилж байгаа ч юм уу.

Тэгэхээр үүнтэй холбоотой энэ танилцуулга дээр ийм би эндээс ганц, хоёр юм асуух гээд байна л даа. Үнэ чөлөөлнө, либералчилна гэдэг чинь мэдээж энэ том асуудал байх. Энэ салбар чинь өөрөө зүй ёсны монополыг бас шаардаж байдаг, өөрөө цөөн нийлүүлэгчтэй, загвар нь өөрөө бас төвөгтэй байх. Үүний цаана зөвхөн ингээд энэ сүүлийн 2 цахилгаан станцын жишээ байна л даа. 600, 600мвт-ын. Нэг нь 28 жилээр гэрээ хийчихсэн. Нэг нь сая сонгуулийн дараа бас 600мвт-ын станц бас 20 хэдэн жилээр гэрээ хийчихсэн гээд. Ингээд 20 хэдэн жил, 20 хэдэн жилээр 600, 600 гэдэг чинь 1000 гаран мвт. Өнөөдрийн байгаа хүчин чадалтай тэнцүү хэмжээний эх үүсвэрийг үнийг ингээд тогтворжуулаад хатуу гэрээ хийгээд тавьчихлаар энэ үнэ чөлөөлөлт гэдэг чинь либералчилна гээд байгаа энэ гоё сайхан өрсөлдөөн оруулна гэдэг чинь яг юу болох юм? Энэ чинь зүгээр бие биеэ хууран мэхэлж байгаа, аль эсвэл 30 дахь жилийн дараа 2050 оноос чөлөөлөх гээд байгаа юм уу энийг? Өнөөдөр хорин дөрөв, таван он, 28 жилийн гэрээ хийчихсэн гэхээр лав л 2050 оноос хойших бодлого ч яриад байгаа юм уу? Тэгээд сая сүүлд тэр сүүлийн Баянгийн станц гээд станц энэ сонгуулийн дараа тэр олон жилийн гэрээ хийсэн байна лээ. Үнэ тариф 8.3 цент билүү хэд гэхихлээ.

Тэгэхлээр энэ чинь энэ Засгийн газрын хөтөлбөр олон олон зүйлүүд нь гарчихсан хойно 20 хэдэн жилийн гэрээ ярьчихаад тэгээд энэ дээр ийм хариулт

өгөөч. Энэ чөлөөлөлт гэдэг чинь зүгээр шоу юм уу, юу юм? Чөлөөлнө гэдгийг би хөвөгч байхыг, эрэлт, нийлүүлэлтээр асуудал шийдэгдэхийг үнэ чөлөөтэй байна гэж ойлгодог. Тодорхой хатуу худалдаж авахгүй бол торгуультай гэрээ хийчихээр энэ чинь өөр асуудал байх. Өөр энэ сэргээгдэхийн асуудал энэ материал дээр ингээд явж байна. Сэргээгдэхийг харахлаар салбарынхан хэлдэг байх эрчим хүчний салбарт 9 хувийг нийлүүлээд 27 хувийг нь орлогыг нь авчихдаг гэдэг гэдэг чинь ойролцоогоор 3 дахин их, нийлүүлснээсээ 3 дахин ихийг авчихдаг байх нь байна л даа. Тэгэхээр ер нь цаашдаа энэ сэргээгдэхийг яах юм? Бид нар ийм гоё сайхан зүйл яриад эдийн засгийн үр ашиггүй, магадгүй ийм шударга ёсны зарчимд нийцээгүй энэ харилцаа энэ эдийн засгийн бүтцийг ингээд цааш нь яг үргэлжлээд байх ёстой юм уу?

Р.Сэддорж: Хариулт хэн бэ? 4 номер.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Олон зүйл дээр бас юу санал нийлж байна. Улс төржиж байсан халамжийн байгууллага, Нийгмийн хамгааллын яам шиг явснаас болоод ийм болчихсон шүү дээ. Нэмж чадахгүй байсан. Социализмаас уламжилсан цөөхөн хэдэн салбар байгаа. Зах зээлийн харилцаанд шилжээгүй. Манай эрчим хүчний салбар байна. Энэ зорчигч тээвэр байна, нүүрс тээвэр байна, нийгмийн даатгалын тогтолцоо бүхлээрээ хуучин хамтын тогтолцооны системд байгаа ийм хэдэн салбаруудын нь манайх мөн.

Үнэ чөлөөлөх асуудал ярьж байна. Хамгийн олон сорилт хүндрэл байгаа юм. тэр Баянгийн цахилгаан станцыг сонгуулийн өмнө улс төржиж янз бүрийн шоу болчихож магадгүй гэж бодоод сонгуулийн дараа гэрээг нь байгуулж өгсөн. 8.4 цент байх аа сүлжээнд нийлүүлэх үнэ нь. Бөөрөлжүүт нь бол 16 оны 3 сард байгуулсан юм байна лээ 8.95 центээр 28 жилийн хугацаатай байгуулчихсан байсан юм байна лээ. Ийм л байгаа. Ийм 28 жилийн дотор орлогыг нь тогтворжуулж, баталгаажуулж өгөхгүй бол хэн ч манай энэ салбар руу хөрөнгө хийхгүй болчихоод аргагүйн эрхэд энийг хийгээд байгаа байхгүй юу. Одоо энэ 8.4-өөс хямдхан байна гээд өөрчлөлттэй мөнгө үүсгээд ороод ирэх бүх хүнд эрчим хүчний салбар бид нар тусгай зөвшөөрлийг нь бичиж өгөхөд бэлэн байгаа юм.

Харин одоо ингээд ер нь ерөнхийдөө хэрэглээгээ гүйцээд эхэлсний дараа хэрэглээнээсээ илүү их хүчин чадалтай болсон тохиолдолд магадгүй тендер зарлах, үнэ чөлөөлөх тухай асуудлуудыг ярьж эхэлнэ. Одоо ямар ч байсан эхний ээлжид энэ чадлаа гүйцэж авмаар байна. Одоо ер нь Монголын эрчим хүчний салбарын түүхэнд жилийн чадлаараа 12 хувьтай, энергиэрээ 7 хувийн өсөлт явуулдаг ийм улс орон ч гэсэн түүхэн цаг хугацаанд их цөөхөн байсан юм байна лээ шүү дээ. Яг ийм хүндрэлтэй хүнд цаг үед бид нар ажиллаж, амьдарч байгаа гэдгээ бас зөв ойлгохоос аргагүй.

Сэргээгдэх эрчим хүчний тухайд бол үнэн. 9-хөн хувийг нь үйлдвэрлэж нийлүүлчхээд 27 хувийнх нь орлогыг нь авчаж байгаа юм. 2006 онд Сэргээгдэх эрчим хүчний хуулийг баталж байх үед иймэрхүү л өндөр үнэ тариф байсан юм байна лээ. 17 центээр шүү дээ. Ийм учраас энэ ийм хүндрэлүүд үүсчихсэн. Холбогдоод ашиглалтад орчихсон байгаа 10 станц бий. Дээрээс нь 3 салхины станц, 8 нарны станц, нийлбэр хүчин чадал нь бас 350 орчим мегаваттын тусгай зөвшөөрөл бичээд өгчихсөн өдөр болгон шаналгаж байгаа ийм өндөр үнээр нийлүүлнэ ээ гэдэг ийм хүндрэлүүд бий. Бид нар ийм өндөр үнэтэй би эрчим

хүчний сайд болсноос хойш нэгийг ч холбуулаагүй байгаа. Тусгай зөвшөөрөлд хуучин 19 оноос өмнө, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт орохоос өмнө ийм тусгай зөвшөөрлүүд бичигдчихсэн юм байна лээ.

Р.Сэддорж: Нэмж хариулах уу? Нэмж хариулах хүн байна уу яамнаас, ажлын хэсгээс? Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Саяын Бөөрөлжүүт, Баян 2 дээр ингээд гэрээ хийгдээд явж байгаа юм. Ажил нь эхлээд яв явж байгаа л гэсэн мэдээллүүд байдаг. Цаашид энэ гэрээнд тодорхой хэмжээний уян хатан өөрчлөлт оруулах ер нь боломж байдаг уу? Үнэ дээр, аль эсвэл тэр нийлүүлэх тоо хэмжээн дээр хатуу үүрэг хүлээчихсэн байдаг уу? Аль эсвэл 600мвт-аар ажиллах станц эрэлт, нийлүүлэлтээсээ хамаараад 300, 400-г нийлүүлэх жишээ нь боломж энэ гэрээнд нь байгаа юу? Яагаад ингэж асуугаад байна вэ гэвэл нөгөө талд нь энэ эрчим хүчний реформ, сэргэлт, гоё гоё мега төсөл гээд баахан юм ярьчаад, энэнд өрсөлдөөн оруулна, зах зээлийн өрсөлдөөнийг оруулна гэдэг зүйлийг засна, нэг гараараа яриад байдаг, нөгөө гараараа 2050 оноос хойш хэрэгжих тэр бодлого тэр хүртэл хатуу үнэтэй байна гэдэг зүйл зохиочихоор чинь энэ 2 чинь зүгээр утга учиргүй хүүхдийн тоглоом шиг ийм яриа болоод байгаа юм биш үү? Энэнд энэ гэрээнд чинь ямар нэгэн уян хатан зүйл байна уу? Засаг, төр наад сүлжээнд заавал худалдаж авах ёстой гэсэн ийм хатуу тэгэхгүй бол шүүхээр шийдэгдэх ийм зүйл, заалтууд нь байгаа юм уу?

Р.Сэддорж: Хариулт 4 номер, сайд.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Та зөв асууж байна. Жилдээ 8760 цаг байгаа. Үүний бид нар 6900 цаг билүү, би 6900 цаг дээр нь саяын ярьж байгаа үнийг нь баталгаажуулж өгсөн. Тэрнээс ч илүү ажиллаад, илүү нийлүүлснийг нь бол тухайн үедээ өрсөлдөөнд ороод явах юм. Эс бөгөөс одоо ингээд бид нар тухайн үед чинь бид нар эрчим хүчний үнийг чинь баталгаажуулж өгөхгүй гэх юм бол ямар ч хөрөнгө оруулагчид энэ салбар руу хөрөнгө хийхгүй болчихоод байгаа байхгүй юу. Ийм л зовлон.

Р.Сэддорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ингээд танилцуулга хийсэн Эрчим хүчний яамныхандаа баярлалаа. Ингээд 6 асуулт байна. Нэгдүгээрт нь болохоор ер нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд эрчим хүчний системийн тогтворжилтод онцгой үүрэгтэйгээр оролцож явах ёстой. Тэгэхээр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр маань ямар үүрэгтэй байх ёстой юм, ямар чадвартай байх ёстой юм бэ гэдгийг бичсэн үндсэн бичиг баримт бол нэгдсэн сүлжээний дүрэм.

Тэгтэл манайх нэгдсэн сүлжээний дүрмээ 2010 оноос хойш шинэчлээгүй, сэргээгдэхүүдэд ямар ч шаардлага тавиагүй ингээд явж байна. Тэгэхээр энэ дүрмийг хэзээ шинэчилж, албан ёсны болгож мөрдөж ажиллах юм бэ? Энэ бол бид нар сэргээгдэхдээ систем маань тогтвортой ажиллах юм уу, үгүй юү гэдгийг тодорхойлдог үндсэн бичиг баримт 2010 оноос хойш ингээд шинэчлэгдээгүй гацчихсан явж байгаа.

Хоёрдугаар асуулт. Өнөөгийн байдлаар 65 ширхэг иргэн, аж ахуйн нэгж 1мвт орчим дээврийн нарны станц холбогдсон ажиллаж байна гэж байна. Тэгэхээр энэ 65 иргэн, аж ахуйн нэгж маань одоогийн байдлаар хэдэн киловатт цагийг сүлжээ рүү нийлүүлээд борлуулчихсан, хэдий хэмжээний орлогыг олчихсон байна вэ? Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт сая цахилгаан эрчим хүчний тариф нэмэгдсэн тэгээд энэ нөгөө хэрэглэгч дээврийн нарны станц тавиад сүлжээ рүү холбох тариф маань 140.18 цент ,140 төгрөг 289 төгрөг гэж ингэж батлагдсан юм байна. Тэгэхээр энэ тариф саяын цахилгаан эрчим хүчний тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ сүлжээ рүү нийлүүлэх энэ тариф нэмэгдсэн үү? Гуравдугаар асуулт.

Дөрөвдүгээр асуулт. Нормчлолын санд жилд хэдэн төгрөг цуглаж байгаа вэ? Эрчим хүчний салбарт хэрэгжиж байгаа бүх төслөөс 0.18 хувиар мөнгө цуглах ёстой. Тэгэхээр энэ сангийн зарцуулалт хэрхэн явагддаг вэ? Жилд хэдэн ширхэг стандартыг шинэчилж сайжруулахад энэ сангаар хийж байгаа вэ гэсэн асуулт байна.

Дараагийн асуулт. Салбарын ерөнхийдөө стандарт, норм дүрмийн шинэчлэлт их тааруу байна гэж харж байгаа. Жишээ нь цахилгаан байгууламжийнхаа дүрмийг 2003 оноос хойш шинэчлээгүй байна. Гэтэл хөгжил дэвшлийн, аливаа салбарын хөгжил дэвшлийн үндэс бол стандарт, бас дахин стандарт. Гэтэл техник, технологи маш хурдацтай хөгжиж байна. Энэ хөгжилтэй хөл нийлүүлэн алхахын тулд бид нар стандартаа шинэчилж орчин үеийн болгож байх ёстой. Нэг тулгуур дээр хэд хэдэн төрлийн хүчдэлийн шугамыг татдаг ийм технологийг олон улс хэрэглээд олон жил болж байна. Гэтэл манай салбар ийм шинэчлэлтийг ч хийдэггүй, стандартаа ч шинэчилдэггүй, стандартаа ач холбогдол ч өгдөггүй. Тэгэхээр хэзээ ийм стандартаа ач холбогдол өгч дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхдаг болох юм бэ гэсэн ийм.../минут дуусав./

Р.Сэддорж: Асуултад их тодорхой хариулаарай. Ийм олуулаа байгаа яамныхан маань асуултад тодорхой хариулна. Энэ өнөөдрийн хурал маш чухал хурал. Эрчим хүчний дутагдалд орсон цаг үед болж байгаа. 1 номер эхлээд хариулъя.

Г.Балжинням: Диспетчерийн үндэсний төвийн гүйцэтгэх захирал Балжинням.

Нэгдсэн сүлжээний дүрмийг анх 2001 онд баталж хэрэгжүүлээд тэр чинь цагаас хойш яг 24 жил, 23 жил болж байна. 2010 он онд мөн шинэчилж баталж мөрдөж байгаа. Энэ дээрээ бид нар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн тогтворжилтыг хангах заалтуудыг оруулаад, тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас бүгдээс нь санал аваад, хэлэлцүүлэг хийлгээд, ингээд Эрчим хүчний ямаар батлуулах энэ үйл ажиллагаандаа ороод явж байгаа.

Р.Сэддорж: Хариулт 2 номер.

Б.Эрдэнэбулган: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Сэргээгдэхийн тархмал эх үүсвэрийн ашиглаж байгаа аж ахуйн нэгж, иргэний 65 иргэний хувьд бол сүлжээнд нийлүүлсэн болон сүлжээнд борлуулсан

эрчим хүчний хэмжээний талаар мэдээллийг Улаанбаатар ЦТС-нээс бид нар харахан аваагүй байна.

Харин энэ тархмал эх үүсвэрийн тариф нь 2021 оны 6 сард батлагдсан байгаа 140 төгрөг, оргил цагт 221 төгрөг гээд жил болгон энэ тариф шинэчлэгдэж байх ёстой. Эрчим хүчний зохицуулах хороо сая хэрэглэгчийн тариф дээр өөрчлөлт орсонтой холбоотойгоор энэ тарифт өөрчлөлт оруулах гээд хорооны урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн. Одоо энэ маань захиргааны хэм хэмжээний акт гарах учраас байгууллагын цахим хуудсан дээр олон нийтээс санал авах гээд тогтоолын төслийг байршуулчихаад байгаа. Бид нар одоогийн байдлаар өдрийн цагт буюу өглөөний 6-17 цагийн хооронд 220 төгрөг төгрөгөөр, оройн буюу 17-21 цагийн хооронд оргил цагийн үед бол 300 төгрөгөөр нийлүүлэх байдлаар шийдвэрийн төслийг бэлдээд байгаа.

Р.Сэддорж: Энэ Байнгын хороодын хурал давхцаад байгаа учраас асуулт асуух гишүүд Агваанлуvsсангийн Ундраа, Ганзоригийн Лувсанжамц гишүүдийг нэрсийг нэмье. Хариулт Энхцэцэг гишүүний асуултад хариулт 4 номер, сайд.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний тэр сүүлийн асуултад хариулъя.

Салбарын норм дүрмийг шинэчлэхгүй байна гээд. Яг үнэндээ Энхцэцэг гишүүн ээ сүүлийн жилүүдэд алдагдалтай явсан учраас норм стандартуудаа шинэчлээд сайжруулчихаар өртөг нь нэмэгдээд байсан учраас, урд хормойгоороо хойд хормойгоо нөхөж байсан учраас би сүүлийн 2 жил эрчим хүчний саад хийхдээ нэмэгдүүлэлгүй байжээ. Ямар ч байсан ингээд багахан шиг хөнгөлөлт хийгээд, хязгаарлалт хийгээд энэ хүнд цаг үеийг давъя гэдэг ийм тооцоололтой явсан.

Сая ингээд эрчим хүчний үнэ, тарифыг нэмэгдүүлэх биш бид нар өртөгт нь дөхүүлэх тухай ярьж байгаа. Энэ шийдвэрүүдийг гараад олон нийт ер нь харьцангуй эсэргүүцэл багатай хүлээж авч байгаа учраас одоо бид нар үе шаттайгаар байгаа боломж, эх үүсвэр, санхүүгийн эх үүсвэр гэдэг хүрээнд энэ стандартуудыг сайжруулаад явна. Ингэхгүй бол хөгжингүй орнуудын стандарт авчраад суурьшуулчих юм бол өртөг нь нэмэгдээд бүтээгдэхүүний чинь өртөг нь нэмэгдээд хэрэглэгч маань өөрөө бас тийм их юу айхтар санхүүгийн төлбөрийн чадвар сайнгүй байгаа учраас энэ ийм стандартуудыг би болгоомжтой нэмүүлж байгаа.

Гэхдээ л бид нар ямар ч байсан жилдээ 20 орчим стандартыг бол шинэчилж явж байгаа. Үүнээс илүү өргөн далайцтайгаар норм стандарт санхүүгийн хүндрэлтэй алдагдалтай байсан учраас нэмэгдүүлж чадахгүй байсныг бас зөв ойлгоосой. Ийм бодлого хэрэгжүүлж байсан шүү.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: 2 асуулт нэмээд асуучихъя. Эрчим хүчний яам хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт суусан ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаад ажиллаж байх ёстой. Тэгэхээр энэ хөтөлбөр дээр хэд хэдэн ажлууд байгаа. 100 мянган дээврийн нарны төслийг хэрэгжүүлнэ ээ төр, хувийн хэвшилтэй хамтарч гээд тэгсэн. Тэгэхээр энэ дээр ямар бэлтгэл ажлууд хийгдэж байгаа вэ? Эрчим хүч экспортолно гээд бас хөтөлбөр дээр байж байгаа, тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ гээд. Тэгэхээр энэ дээр ямар байдлаар

хэрэгжүүлэхээр нарийвчилсан төлөвлөгөө гаргачихсан ажиллаж байгаа вэ гээд асуулт.

Дараагийн асуулт болохоор Архангай, Өвөрхангай, Баянхонгорт 10мвт-ын нар, 20 мегават цагийн батарей суурилуулахаар 2025 оны Монгол Улсын хөгжлийн хөтөлбөр суурилуулсан. Тэгэхээр энэ төслүүдийн бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байгаа вэ 25 онд ? Хэдэн сард энэ ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ гэсэн 2 асуулт.

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүн ээ энэ мөрийн хөтөлбөр дээр манай Эрчих хүчний яамнаас гадна Эдийн засаг, хөгжлийн яам боловсруулахдаа бид нарт мэдэгдэхгүйгээр хэд хэдэн заалт оруулсан. Бид би яг Эрчим хүчний яам өөрсдөө мэдэхгүй байж байгаад Их Хурал дээр ч нэмэгдсэн зүйлүүд бий. Бид нар энэ төслүүдийг хаанаас хэн, ямар санаатай, ямар тооцоололтой хийснийг нь нөхөж хайгаад судалж хөгжүүлэлтдээ явж байгаа юм.

Тэгэхээр одоохондоо яг бэлэн биш байгаа учраас танд бэлэн болоод судлаад мэдээллийг нь оруулсан хүмүүсээс нь нөхөж аваад эргэж танилцуулъя.

Р.Сэддорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүнийг нэмье. Бямбасүрэн гишүүнийг нэмье. Ингээд Цэнгүүн гишүүн байхгүй байна тээ? Агваанлувсангийн Ундраа гишүүн асуулт асууя.

А.Ундраа: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 3 асуулт байна.

Нэгдүгээрт сайдаас асуухад энэ Засгийн газрын бүтэц батлагдах үед энэ маш олон үндэсний хороо ингээд бас шинээр байгуулагдаад, эрчим хүчний сайд асуудлаа хариуцаад ажлаа хариуцаад ингээд ажиллаж байхад чинь Эрчим хүчний үндэсний хороо гээд ингээд давхардсан бүтэц бий болгоод, ажлыг удаашруулаад, нэмэлт зардал, үргүй зардал гараад байна гэж харж байгаа.

Тэгэхээр таныг ажлаа хийх явцад энэ давхардсан бүтэц ер нь хэр зэрэг ямар байдлаар нөлөөлж байгаа юм. Эерэг үү, сөрөг үү гэдэг талаар та яг өөрийнхөө дүгнэлтийг хуваалцвал сайн байна.

Хоёрдугаарт, Эрчим хүчний зохицуулах хороо эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ олгож байгаа. Тэгэхээр хэдэн аж ахуйн нэгж энэ эрчим хүчний хэмнэлт хийж, хэдэн хувийн хэмнэлт хийсэн талаар энэ танилцуулгад мэдээлэл би олж харсангүй. Тэгэхээр эрчим хүчний хэмнэлт хийхийг мэдээж эрчим хүч үйлдвэрлэж байгаа талаасаа харах юм бол аль болох их үйлдвэрлэж борлуулбал орлого олно.

Гэхдээ нөгөө талдаа хэдий чинээ сайн хэмнэнэ төдий чинээ үйлдвэрлэх хэрэгцээгээ бууруулна гэдэг нь бас нөгөө нийт дүндээ бас эерэг нөлөө үзүүлнэ хэмнэх нь. Тэгэхээр хэмнэлтийн талаар та нөгөө нөхцөл байдлын талаар товчхон хэлнэ үү?

Гуравдугаар асуулт сая цахилгааны эх үүсвэрээр халаах тэгээд дулаалгыг шийдэх юм бол нийтдээ 2 гега ваттын эх үүсвэр шинээр хэрэгтэй гэдэг тийм таамаг тойм та хэллээ.

Гэтэл жишээлэхэд дулаалгыг хийснээр, сайн дулаалснаар эрчим хүчний хэрэглээгээ бууруулах боломж байгаа. 2 гега ватт биш, 1 гега ватт руу оруулах 50 хувийн дулаалга хийж нөгөө хэрэгцээгээ бууруулснаар төдий чинээ үйлдвэрлэх хэрэгцээ, шаардлага нь багасна шүү дээ. Тэгэхээр энэ талаар ямар бодлого баримталж байна? Ер нь нөгөө үйлдвэрлэхгүй байх нь, үйлдвэрлэх хэрэгцээ байхгүй байх нь төдий чинээ агаарын бохирдлыг бууруулах, тэгээд эрчим хүч үйлдвэрлэж байгаа тохиолдолд тэгээд бусад төрлийн нүүрсхүчлийн давхар исэл хий ялгаруулах, хүлэмжийн хий ялгарлын бууруулах гээд олон талын дам эерэг нөлөөтэй шүү дээ. Тэгэхээр тэр дулаалгын асуудлыг яагаад ерөөсөө дурдахгүй байгаа юм бэ? Эхний ээлжид дулаалаад, дараагийн ээлжид үйлдвэрлэх нь угаасаа зарчмын хувьд логик дараалал биш юм уу?

Р.Сэддорж: 4 номер хариулт.

Б.Чойжилсүрэн: Ундраа гишүүний тухайд Эрчим хүчний үндэсний хороо гэдэг юм байгуулаад илүү зардал гаргаж байна гэдэг ийм утгаараа та ярив шиг гэж.

Эрчим хүчний үндэсний хороо байгуулсан гол үндсэн шалтгаан бол энэ 3 нам хамтарч Засгийн газар байгуулсан шүү дээ бид нар. Энэ 3 нам чинь нийлээд энэ хүндэрсэн асуудлаа бодит амьдралаа ингээд ард түмэнд хэлээд энийг шийдье гэж хамтарч ямар нэртэй зориг билээ. Бид нар чинь ийм гоё нэртэй Засгийн газар байгуулсан шүү дээ.

Тийм учраас улс төрийн шийдвэр гаргаж нөгөө намуудыг ч бас ер нь эргээд дан ганц дандаа бүх юм л МАН гэдэг юм биш. Бусад энэ нэг Монгол Улс учраас энэ улс Их Хуралд суудалтай бусад намууд ч гэсэн энийг улс төрийн хувьд дэмжээсэй гэдэг үүднээс улс төрийн шийдвэр гаргуулахад мэдээж их тус болсон. Энэ үндэсний хороонд ажиллаж байгаа гишүүд маань үнэхээр бас сэтгэл зүрх гаргаж ажиллаж байгаа. Би хувьдаа талархаж байгаа. Бидний хувьд ямар нэгэн тийм үл ойлголцол маргаан байхгүй байгаа гэдгийг бас нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, дан ганц эрчим хүчний Ардын нам бид нар бүх асуудалд биш, нөгөө 2 намын мөрийн хөтөлбөрт суусан дэвшилттэй заалтууд байвал тэрийг нь яагаад хамтраад хэрэгжүүлж болохгүй гэж гэдэг. ийм бодлого юу гараад энэ эрчим хүчний үндэсний хороо, реформын үндэсний хороо байгуулагдсан ийм байдалтай байгаа гэдгээ хэлье.

Мэдээж юу энэ дулаалгыг нэмснээр дулааны эрчим хүчний нэн ялангуяа хэмнэлт гарна гэдэг нь ойлгомжтой байгаа зүйл. Энд нэгдсэн Улсын комисс ажилладаг нийтийн орон сууцууд бол дулааныхаа алдагдлыг бол тэртээ тэргүй цаанаасаа зургийг нь батлахдаа стандартыг нь тавиад батлуулчхаж байгаа юм. Хамаг хүндрэлтэй сэдэв бол энэ урьдын жилүүдэд байсан, гэр хороололд байгаа хуваариа барьсан энэ хувийн гэр орон сууцууд бол дулааны алдагдал бол өндөр алдагдалтай байгаа нууцгүй зүйл. Үүнээсээ шалтгаалаад уул нь дулааны хэмжээ зарим байшингууд дээр 2 дахин өндөр зарцуулагдаж байна гэсэн ийм тооцоолол бий. Бид нар эрчим хүчний үнийг, манай Эрчим хүчний яам ийм халамжийн яам шиг байж байгаад үнэгүйдүүлээд хямдхан байгаад байснаас шалтгаалаад дулаалчих юм бол эрчим хүчний үнэ зах зээлийнхээ үнэд хүрчих юм бол тэр дулаалсан нь ашигтай болох ийм нөхцөл биш хэт хямдхан үнэгүйдүүлснээс шалтгаалаад бас энэ ийм дулаалах асуудлыг бол хойрго хандсан ийм шалтгаанууд бий.

Одоо. ингээд зах зээлийнхээ үнэд очоод эхлэх юм бол тэртээ тэргүй тэнэг биш шүү дээ хүн болгон, хэрэглэгч болгон дулаалга хийж таарна, бага дулааны төлбөр төлөхөө хичээж таарна шүү дээ энэ чинь. Бид нар хэт үнэгүйдүүлээд байсан байхгүй юу. Бас буруу. Төр тариф болгоод улс даяар 1 үнээр мөрөөддөгөөс байснаас шалтгаалаад, зах зээлийн харилцаанд гүйцэд ороогүй байснаас шалтгаалаад ийм таны яриад байгаа шүүмжлэлт байдлууд үүссэн. Одоо энэ асуудлууд шийдэгдэх ёстой гэж бодож байгаа. Аль ч гэсэн энэ дулаалгад хийсэн хөрөнгө оруулалт бас л өөрийгөө нөхдөг үр ашигтай байх ёстой энэ тооцоолол нь урьд нь бий болохгүй байсан нь одоо бий болох болов уу гэж бас найдаж байгаа.

Р.Сэддорж: 3 номер нэмж хариулъя. Өөрийгөө бас танилцуулаарай.

П.Товуудорж: Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Товуудорж.

Эрчим хүчний хэмнэлтийн хуулиар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хэмжээг босгохыг Засгийн газраар тогтоох ёстой. Тэгээд 15 онд Эрчим хүчний хэмнэлтийн хууль батлагдсанаас хойш энэ журам нь 17 онд батлагдаад энэ босгыг өнгөрсөн 23 онд шинэчилж тогтоосон байгаа. Тэгэхээр үүрэг хүлээсэн хэрэглэгчийн тоо ерөнхийдөө 297 байна уу 300 орчим байгаа. Тэгээд анх 15 онд батлагдсанаас хойш энэ эрчим хүчний жинлэлт хэмнэсэн хэмнэлтийн тоо нэлээн өндөр яригддаг байсан. Тухайн үед мэдээж хэмнэлтийг анх яригдаж байсан учраас арга хэмжээнүүд аваад одоо бол өнгөрсөн жил 16.9 сая квт цаг эрчим хүчийг үүрэг хүлээсэн хэрэглэгчид хэмнэсэн гэсэн гэсэн ийм тоо гарч ирсэн байгаа байгаа. Энэ тоог ерөнхийдөө бид нар бас бодит тоо гэж харж байгаа юм. Урьд нь бол ТЭЦ, Эрдэнэтийн станц, Дарханы станц үйлдвэрлэсэн хэмжээний эрчим хүчийг хэмнэлээ гээд л янз бүрийн тоонууд, өндөр тоонууд явдаг байсан.

Тэгэхээр одоо бол энэ хэмнэлтийн хэмнэж байгаа эрчим хүч маань цаашаа нөгөө хүлэмжийн хийн зах зээлтэй бас холбогдож байгаа учраас нөгөө олон улсад MRV гэдэг аргачлалаараа илүү нягтлаад ирэхээр ийм бага тоо гарч байгаа гэж бид нар.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт болсон уу? Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. 3 асуулт байна.

Эхнийх нь болохлоор Засгийн газраас цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлт гэж эдлүүлж байгаа. Өнгөрсөн жил 210 мянган өрхөд, 2025 онд 223 мянган өрхөд олгоно гэж байгаа. Энд ямар хэмжээний төсөв зарцуулж байгаа вэ? Татаас олгож байгаа бэ? Мөнгөн дүнгээр нь мэдмээр байна.

Хоёрдугаарх нь болохлоор нийслэлд олон айл өрхүүд байшин гэрээ дулаалаад утаагаа багасгачихъя гээд чадлаараа бас олон өрхүүд цахилгаан халаагуурт шилжиж байгаа. Эсрэгээрээ хүчдэл нь хүрэхгүй эргээд галлагаандаа шилжиж байгаа өрхүүд бас их байгаад байгаа. Энэ талаар судалгаа хийж байгаа юу? Аль бүс дээр өрхүүд цахилгаанд шилжсэн боловч хүчдэлд нь хүрэхгүйгээр буцаад галлагаандаа ороод байна? Аль хэсэг дээр дэд станцуудыг томруулах шаардлагатай, аль хэсэг дээр шугам сүлжээний бүрэн бүтлийг хангах шаардлагатай гэсэн судалгаа байна уу?

Дараагийн асуулт нь болохлоор сая Засгийн газрын хуралдаанаар утаагүй бүсийг тодорхойлсон гээд Улаанбаатар хотод мэдээлэл явж байсан. Энэ утаагүй бүсэд байгаа айлуудын халаалтыг нь цахилгаанаар шийдэх гэж байна уу, эсвэл өөр байдлаар шийдэх гэж байна уу? Энэ бүсүүдийнх нь хэмжээ, байршил тодорхой болсон байгаа юу?

Хамгийн сүүлийнх нь жоохон танилцуулгын 3 дугаар бүлэг дээр байгаа салбарын бүтцийн реформын асуултыг асууя. 2 үе шаттайгаар буюу эхлээд үнээ нэмье, хоёрдугаарх нь энэ салбарынхаа реформ бүтцийн реформыг хийе гэж байгаа тээ.

Бүтцийн реформыг хийхэд 2, 3 зүйл чухал гэж бодож байна. Аливаа улсад эрчим хүчний салбарын стратеги төлөвлөгөө гээд 3-5 жилийн төлөвлөгөө гараад хэрхэн сэргээгдэх эрчим хүчээ нэмэх вэ, эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэх вэ гэсэн тийм төлөвлөгөө гардаг. Миний ойлголтоор бол Эрчим хүчний зохицуулах хорооноос тийм стратеги төлөвлөгөө гараагүй байгаа гэж ойлгосон. Энийг хэзээ гаргах вэ? Энэ нь дотроо ТӨК-удын хөрөнгийн өгөөж буюу “Ар Өү Ви” гэж хэлдэг энийг хэдэн хувиар тооцох вэ? Тэр түвшиндээ хэзээ хүрэх вэ? Хамгийн сүүлийнх нь болохлоор бид нар нэгэнт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт дуудах гэж байгаа бол Засгийн газраас хөрөнгө оруулалтын өгөөж буюу “Ар Өү Ай” гэж тодорхойлж өгдөг. Тэгэхгүй бол хувийн хэвшлүүдийн хөрөнгө оруулалт хэрэгждэггүй тээ. Энийг бас энэ бүтцийн реформ дотроо тусгаж өгөх ёстой гэж бодож байна. Энэ ажлуудыг хэзээ хийх вэ гэдгийг цаг хугацааны асуултыг асууж байна.

Р.Сэддорж: Хариулт 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц Жамц гишүүний асуултад хариулъя.

Шөнийн тарифын хөнгөлөлтийн талаар асууя бололтой. Засгийн газрын 199 дүгээр тогтоол гэж бий. 10 мянган хүн амаас дээш хүн амтай хот, суурин газруудад 2017 онд энэ улс Засгийн тогтоол батлагдаад шөнийн тарифын хөнгөлөлтөд хамрагдаж байгаа. Эрчим хүчний сайдын төсвийн багцад 2024 онд 50 тэрбум төгрөг суусан байгаа. Гүйцэтгэл жил ирэх тусам аягүй нэмэгдээд явж байгаа. 20 хэдэн тэрбум төгрөгөөс эхлээд л одоо ингээд 50 тэрбум руу хамрагдаж байгаа айлын тоо, хамрагдалтын хязгаар хөнгөлөлтийн хязгаарууд нэмэгдээд явж байгаа ийм тооцоо байгаа байна гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, энэ Улаанбаатар хотын 2040 гэдэг энэ хөтөлбөр нь бид бид нарт мэдэгдэхгүй байгаа, эцэслээгүй байгаа. Тэгэхээр бид нар яг өнөөдөртөө шулуухан үнэнийг хэлэхэд эрчим хүчний чадлын дутагдалд орчихсон байгаагүй улсууд чинь бид нар утаатай гэхээсээ түрүүлээд аль болох бага хязгаарлалт хийх нь тэргүүн зэргийн зорилт болчихсон байгаа учраас би бол Эрчим хүчний сайдын хувьд цахилгаанаар халаагаач гэдэг ийм уриалга хийхгүй байгаа. Одоо хэрэглээнийхээ өсөлтийг эх үүсвэр маань дамжуулах сүлжээ хуваарилах байгууламжууд маань давж урд талд нь гарсны дараа энэ асуудлуудыг ярина.

Ер нь та инженер хүн нэг зүйл ойлгомжтой шүү дээ. Манай энэ дотоод шаталтын энэ хөдөлгүүр маань 27-хон хувийг нь ашигт үйлийн коэффициенттой. Энэ чинь шууд анх нүүрс шатаагаад цахилгаан эрчим хүч болоход 73 хувийг нь бид нар алдчихаж байгаа шүү дээ. Ийм өндөр эд шүү дээ энэ чинь. Та яг үнэнийг лакшери бүтээгдэхүүн болчихоод байгаа байхгүй юу. Яг энэ цахилгаанаар

буцаагаад халаана гэдэг бол нэлээн тийм тансаг хэрэглээ гэж ойлгож болохуйц ийм шүү дээ. Эрчим хүчний бүх мэдэж байгаа. 27-хон хувийн ашигт үйлийн коэффициент шүү дээ.

Тийм учраас энэний хувьд бол ядуу байгаа үед бол тодорхой хэмжээнд бас боломж чаддаг юмаа ярихгүй бол чадахгүй баахан юм амлаад бусад хүмүүст, олон нийтэд бол хоосон горьдлого хүлээлт үүсгээд ингээд баймааргүй байна. Бодит юмыг нь бодитоор ярьсан нь дээр, зөв болов уу гэж би ийм байр суурьтай байгаа шүү.

Энэ бүтцийн реформ хийхэд энэ их олон далайцтай олон жилийн ажил болох юм байна лээ. Эхний ээлжид би 22 оны 8 сард Эрчим хүчний сайдаар түрүүчийн бүрэн эрхийн хугацаанд томилогдоод очихдоо ямар ч байсан манай эрчим хүчний салбарын энэ бүртгэлийг олон улсын стандарт руу хэрэгжүүлэх гэж нэлээн ажил шахаж явж байгаа. Энэ ажил маань ямар ч байсан хийгдээд явж байгаа. Танд юу жишээ болгоод хэлэхэд ТЭЦ 4-өөс бид нар 80 төгрөгөөр л сүлжээнд нийлүүлж байгаа шүү дээ. 2.3-хан цент. Хөрөнгө оруулалтын өгөөжийг элэгдлээр нь гаргаад авах юм энэ яавч 7, 8 центээс доошоо буухгүй ийм тооцоо гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар чинь энэ төрийн өмчийг бас үнэгүйдүүлээд нөгөө халамжийн яам гэдгээрээ бараг Халамжийн яам гэдэг нэртэй байсан. Ийм үнэгүйдүүлсэн тооцоонууд бий.

Тэгэхлээр эхний ээлжид энэ өртөг рүүгээ дөхүүлээд ирэх юм бол бид нар үнэ тарифыг нэмэгдүүлсэн юм биш шүү дээ, өртөгт нь ойртуулах эхний арга хэмжээ сайн авсан. Энэний дараа бол тэр манай энэ салбар руу ямар ч байсан бүүр хувьцааны дийлэнх биш гэхэд тодорхой хэмжээг нь бол олон нийтэд санал болгож хувийн салбарын хөрөнгө оруулалт, хувийн салбарын хяналтад аваачиж хийх юм бол энэ ТӨК-уд дээр иддэг уудаг, шамшигдуулдаг гэдэг энэ хардлага, шүүмжлэл байдаг. Энэнээс бас салах юм даа гэсэн ийм байр суурьтай байгаад байгаа юм. Тэр хүрээндээ таны яриад байгаа бусад асуудлуудыг бол бид нар тавина.

Мэдээж энийг бол алсын зорилго бол эрчим хүчний салбарын либералчлал шүү дээ. Өөрсдөө эмийн салбар руу хувийн салбар оруулаад ашгаа олдог “Ай Ар”-аараа тухайн үеийнхээ улс орон.../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер хариулт гүйцээе.

Б.Чойжилсүрэн: Хөрөнгө оруулалтын өгөөж “Ай Ар” гэхэд бид нар ингэ манай Засгийн газрын бонд 8 хувьтай байвал хувьцаанд хөрөнгө оруулаад ашиг олно гэвэл доор хаяж доллароор нөгөө тэрнээсээ доор хаяж 2-оос 3 пукет дээр байж таарна даа. 10,11 хувийг нь өгөөжийг валютаар хүлээж байж энэ рүү салбар руу чинь орно. Тэгэхгүй бол томьёо болгоё гэсэн засгийн бонд аваад хэвтэж байсан нь дээр биз дээ хөрөнгө оруулагч.

Тийм учраас энэ манай ерөнхий эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад хөрөнгө оруулалтыг тухайн үед нь, тухайн мөчид нь ашигтай байхаар л ингээд л тооцоод явах хөвөрч хүйгээр ийм бодолтой байгаа.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн . Хариулт дуусаагүй байна уу? 3 номер. Хариулт үргэлжилж байна.

П.Товуудорж: Түрүүн бас энэ Жаргалан гишүүний асуулт дээр давхацсан учраас энэ агаарын бохирдол цахилгааны үнэ нэмсэнтэй холбоотой галлагаа руу шилжчихэв үү гэдэг ийм асуудал яригдаад байгаа. Тэгэхээр энэ дээр зохицуулах хорооноос Улаанбаатар ЦТС рүү судалгаа хийхээр үүрэг даалгавар өгөгдчихсөн байгаа Улаанбаатар хотын...бүрээр. Өнгөрсөн жилийн яг мөн үетэй гадаа агаарын температурыг харьцуулаад ерөнхийдөө манай Диспетчерийн үндэсний төвөөс гадаа агаарын температур 1 градусаар чангарахад 10мвт-аар ачаалал нэмэгдэж байна гэдэг ийм зүйл ярьдаг.

Тэгэхээр энэ жил бол өнгөрсөн жилээс харьцангуй дулаахан байгаа. Гэхдээ ачаалал бол өнгөрсөн жилээс нэмэгдээд 1651 байх. 1651мвт хүрсэн. Тэгэхээр саяын агаарын бохирдол ер нь яг дулааран хүйтрэхийн шилжилтийн процесст бас инверс гээд цаг уурын энэ юу байдаг. Тэгэхээр Улаанбаатар хотод бас энэ нь тохиогоод агаарын бохирдол бас нэлээн хэд хоног хүндээр үргэлжилсэн болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ судалгааг гарахаар та бүхэнд танилцуулъя.

Р.Сэддорж: Хоёр гишүүнд та судалгааг бичгээр өгөх нь байна шүү. Тийм ээ? Жаргалан гишүүн, Лувсанжамц гишүүн. Тодруулж асууя Лувсанжамц гишүүн.

Товч тодорхой ихэнх асуултуудад товч тодорхой хариуллаа. Баярлалаа.

Г.Лувсанжамц: Гурав дахь асуусан нь энэ эрчим хүчний салбарын стратеги төлөвлөгөө гэж байгаад байгаа тэрийг нөгөө цаг хугацааны хувьд хэзээ боловсруулж Эдийн засгийн байнгын хороон дээр танилцуулах боломжтой вэ гэсэн тэр асуултад хариулт авсангүй.

Р.Сэддорж: 4 номер сайд.

Б.Чойжилсүрэн: Эрчим хүчний салбарын стратеги төлөвлөгөө гээд үйлдвэрлэчихсэн ийм юмнууд байгаа Дэлхийн банктэй ч хамтарчихсан. Харамсалтай нь яг бодит байдалтайгаа нийлдэггүй юм. Тэгээд би бол бидний баримжаагаар шүү чадлын дутагдал бол бид нар 2030 он он гэхэд, би 6 жилээс илүү цаашаа төлөвлөж чадаагүй. Энэнээс цаашаа төлөвлөдөг мундаг ухаантай хүн ч хэцүү байх. Манайх шиг ийм уул уурхайн орны хувьд. Ингэхлээр 3000 цахилгаан эрчим хүч, жишээлбэл 3200 орчим мега ватт болох юм болов уу гэсэн ийм тооцоолол байдаг юм. Энийг яаж хангах вэ гэдэг нэгдүгээр зорилгоо бид нар хийгээд явж байгаа. Энэ төлөвлөлт бэлэн байгаа. Танд хүргүүлье. Энэ дээр 1 микрофоны, 1 минутын асуулт хариултын горимоор бүгдийг нь ярих бололцоо алга байна.

Р.Сэддорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би ганц л асуулт асуух гэсэн юм.

Эрчим хүчний найдвартай ажиллагааг хангахад бас урдаас холбох бололцоонууд байгаа. Тэр дээр шугамын ажил сая төсвийн хэлэлцүүлгийн үеэр бас танилцуулагдаж байсан. Оюутолгойгоос энэ төвийн эрчим хүчний сүлжээнд холбох богинохон холболт энэ асуудал байгаа. Тэгэхээр энэ ажлын явцын талаар мэдээлэл өгөөч. Хэзээ амжихаар байна, төлөвлөсөн хугацаандаа амжихаар байна уу? Энэ холболт хийгдвэл бас 2 талтай холболт хийгдээд энэ тасалдалгүй байдал дээр бас аюулгүй байдлаа нөхөх, хангаж ажиллах бололцоо боломж бүрдэнэ гэж ойлгоод байгаа. Энэ талаар бас та илүү мэдээлэл өгөөч. Баярлалаа.

Р.Сэддорж: 4 номер. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ Оюутолгойн дэд бүтцийг ашиглаад Өвөр Монголын эрчим хүчний системээс бид нар 77мвт-ын хүртэл цахилгаан эрчим хүч шаардлагатай тохиолдолд импортолъё гэдэг ийм тооцоолол хийгээд бэлтгэл ажлыг нь хангаж байгаа юм. Энэний дэд бүтцийн ажлыг хийхэд шаардлагатай 19, 20 орчим сая долларыг “Оюутолгой” компани гаргасан. Өнгөрсөн 2023 оны 9 сард ТУЗ-аар нь батлуулаад харамсалтай нь өнөөдрийг хүртэл Оюутолгойн өөрийнх нь стандарт захиалагч нь Оюутолгойн өөрөө санхүүжилтийг гаргаж байгаа учраас “Оюутолгой” компани хийж байгаа. Энэ оны 1 дүгээр сардаа багтаагаад энэ 77мвт-ын цахилгаан эрчим хүч импортолсно Хятадаас.

Гэхдээ нэг зүйл байгаа шүү. Манайх чинь хуучин ОХУ-тай зэрэг ... байсан манай Монголын систем. Ийм улс. Хятадтай зэрэгцээ яахын тулд back to back тавих юм уу бид нар ингэж байгаа. Тэр back to back станц тавих юм бол дахиад 100, 200-гаад сая долларын асуудал үүсэх учраас бид нар Сонгино дэд станц хүртэл нь 77мвт-ын хэрэглэгчийг тусад нь салгаад Хятадтай зэрэгцээ ажиллуулахаар ийм техникийн шийдэл гаргаад явж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, яг өнөө маргаашдаа ба багтаад, энэ ондоо багтаагаад бид нар Хятадууд эрчим хүчнийхээ үнийн тарифыг одоо ингээд л өгнө өгнө гээд л бид нар шахаад л яваад байгаа. Энэ ондоо багтааж өгөх болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. 2 ч удаа, 3 ч удаа энэ намар бид нар урьж авчирсан Өвөр Монголын эрчим хүчний системийг. Ийм байдалтай. Ямар ч байсан энэ 2025 оны 1 дүгээр сарын дундуур гэхэд бол тэр Оюутолгойн дэд бүтцийг ашиглачих болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компани энэ дээр бас давхар нэмэлтээр ороод ажил хийж байгаа. Оюутолгойн зарласан тендер, шалгарсан компани дээр нь нэмэхэд.

Р.Сэддорж: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууна.

Ш.Бямбасүрэн: Сайн байна уу? Та бүхэндээ энэ оройн мэнд хүргэе.

Манай эрчим хүчний салбар бол бүр ёстой ужгирчихсан олон жил болж байгаа, салбарынхан бол олон жил ярьсан. Харамсалтай нь манай сайдын хэлж байгаа шиг халамжийн байдлаар ингээд улс төрчид нь хараад дэмжихгүй яваад байсан. Гэхдээ энэ удаагийн Засгийн газар бол эрчим хүчний салбарыг бол хамгийн ихээр ойлгож дэмжиж явж байгаа. Хөрөнгө оруулалтууд бол бараг л дийлэнх нь л эрчим хүчний салбар руу явж байгаа.

Тэгэхээр би энэ Лувсанжамц гишүүний төстэй асуулт асуух гээд байна л даа. Түрүүн бас ажлын хэсэгт байж байгаад хоцорч орж ирсэн болохоор асуулт бас давхцаж байж магадгүй. Ер нь бид нар яг чадлаа хэдэн онд гүйцэх юм? Ямар ямар хүчин чадалтай, энэ танилцуулга дээр байгаа юмнууд болохоор бас л их бүтэлгүй юмнууд сонсогдоод байна. Эгийн гол гээд тэгсэн чинь бас гомдол гаргасан байгаа л гэнэ, Тавантолгойн станц нь бас шүүхийн маргаантай яваа л гэнэ.

Тэгэхээр яг бид нарт яг болж бүтэж байгаа яг ойрын хугацаанд ашиглалтад орох шинэ цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүд хэд байх юм бэ? Бид нар ер нь хэзээ чадлаа гүйцэхээр төлөвлөж байгаа юм бэ гэж асуумаар байна. Нийт үйлдвэрлэж байгаа эрчим хүчний хэд нь, яг хэдэн төгрөгөөр байна? Одоо станц болгоноор, байгууллага болгоноор нь над руу ингээд бичгээр хүргүүлж өгөөч. Үнэ бол харьцангуй өөр өөр байгаа шүү дээ. Өртгийн хувьд бол. Тэгээд тэрийг ингээд бас гаргаж өгөөч.

Яагаад энийг асуугаад байна гэхээр бид нар шинэ эх үүсвэр барихдаа эдийн засгийн хувьд бол үр ашигтай газар руугаа уг нь өргөтгөл гэдэг юм уу, хөрөнгө оруулалтаа ингээд хийж эх үүсвэрээ нэммээр байгаа юм. Тэгэхгүй ингээд хөрөнгө оруулалт олдохгүй байна гэнгүүтээ аягүй үнэтэйгээр бас ингээд хэт хувийн хэвшлийн юу руу харж байна гээд аягүй өндөр өртөгтэйгээр явал урт хугацаандаа бас бид нар аягүй тийм эдийн засгийн хувьд үр өгөөжгүй ийм юм руу орох гээд байгаа юм шиг санагдаад байгаа юм.

Нөгөө талаас бодлогын хувьд бид нар ер нь өнөөдөр ч дутагдалтай явж байгаа болохоор хэцүү л байгаа байх л даа. Гэхдээ ер нь бид нар сэргээгдэх эрчим хүчийг ер нь ямар хувьтай барих юм гэдэг бодлого юмнууд ер нь Эрчим хүчний яаман дээр маань байгаа юм уу? Яагаад гэвэл бид нар Тавтолгойгоо барилаа гэхэд Оюутолгой дээр жишээлбэл 30 хувь нь заавал сэргээгдэх байна гэдэг гэрээтэй байдаг гэж би дуулсан. Тэгэхэд тэрийгээ хангаж чадахгүй хэмжээнд байгаа юм уу, ямар байгаа юм бэ гэдэг асуулт байна.

Төгсгөлд нь энэ Эрчим хүчний яаман дээр 27 хувьцаат компани харьяалалтай байдаг юм байна. Тэгээд энэний үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр яам ер нь ямар бодлого барьж ажиллахаар байна вэ? Ингээд харахаар үр ашигтайнууд нь бас 23 оны санхүүгийн юугаар байна? Ашиггүйнүүд нь ч бас нэлээн байна. Энэний ер нь үр ашгийг ер нь яаж.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя.

Яг энэ хэрэглээгээ эх үүсвэр маань 2027 оны 6 сарын 30-нд 1 удаа гүйцнэ. Гэхдээ энэ тэгээд 1 удаа гүйцчихээд хаячих юм бол бас бүтэхгүй. 1 хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр бид нар 2 хөршөөсөө дөр 4 дахин бага байгаа байхгүй юу. Бид нар чинь хүссэн техникийн нөхцөл хүсэж байгаа тэр хүсэлтүүдийг бол биелүүлэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр ойрын жилүүдэд бол энэ хэрэглээ өсдөгөөрөө өсөөд жилдээ 12 орчим хувиар явна гэсэн үг. 12 хувь гэдэг маань бид хэмжээнд яах юм бол 2 гигабайт боллоо гэхэд чинь 240мвт-аар л жил болгон нэмэгдэнэ гэсэн үг. Энийг бид нар цаашид үргэлжлээд эдийн засгийнхаа энэ тэлэлтийг дэмжихийн тулд цаашид ингээд л явна.

27 онд ямар ч байсан 1 удаа энэ Засгийн газрын үед гүйцэж авна. Түүнээс цаашид тэгээд гүйцчихлээ гээд санаа амраад хаячихгүйгээр жил болгон 250мвт-аас-аас доошгүй, магадгүй 300мвт-аас доошгүй чадлыг нэмж ашиглалтад оруулж, холбогдох цахилгаан дамжуулах шугам хуваарилах байгууламжуудын хамт авч явж байж бид нар энэ хөгжиж байгаа яг энэ цаг үеийг давах ийм тооцоолол гарах болов уу гэсэн ийм байна.

Хоёрдугаарт, энэ станцуудаас бид нар дотоод дээрээ байгаа шүү дээ энэ чинь ийм 4 дүгээр цахилгаан станц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээд, дамжуулахаар дамжуулаад, түгээх сүлжээгээр дамжуулаад хэрэглэгч дээрээс бид нар цахилгаан эрчим хүчний төлбөр авч байгаа шүү дээ. Дотоод тарифыг Эрчим хүчний зохицуулах хороон дээр баталж байгаа.

Жишээлбэл, 3 дугаар цахилгаан станц тэр Их Хуралд бид нар юу өргөн барих гэж байна ОХУ-тай нөгөө зураг төсөл боловсруулах Засгийн газар хоорондын комиссын хуралдаан. Тэр чинь ойролцоогоор бараг 20-иод сая доллар болох болов уу гэсэн ийм тооцоолол. Тэгэхээр энийг 3 дугаар цахилгаан станц дээр тарифыг нь, дотоод тарифыг нь өөрчилж байж Зохицуулах хороон дээрээс бид нар энэ хэмжээний эх үүсвэрийг гаргах ийм л зохиц уян хатан зохицуулалттай сүүлийн жилүүдэд явж байгаа. Тогтмол ийм тарифаар мөрдөж чадахгүй ийм нөхцөл байдал байгаа. Амьдрал өөрөө ийм зүйлүүдийг шаардаж байгаа гэдгийг хэлье.

Оюутолгойн тухайд бол 2 тэрбум квт цаг эрчим хүч хэрэглэх юм шиг байна лээ. Манай төвийн бүсийн эрчим хүчний системээс 1.3 квт цагийг нь дотоодын эрчим хүчнээс хангана. гэсэн. Энд нь тааруулаад Тавантолгойн цахилгаан станцыг 300мвт-аар эхний 2 блокийг нь тендер зарлачихсан байсан юм. Үлдэж байгаа тэр 700 сая дээр нь бол бас Оюутолгой компани өөрөө тендер зарлаад Монголын дотоодын аж ахуйн нэгж шалгарчихсан юм байна лээ.

Гэхдээ нэг асуудал бий. Монгол Улсын Засгийн газрын 34 хувийн оролцоотой “Оюутолгой” гэдэг компанийн цахилгаан эрчим хүчний үнэ чинь тэр сэргээгдэх эрчим хүчний үнээс гадна Өвөр Монголын эрчим хүчний системээс чадлын захиалга хийнэ. Энийгээ өнөөдрийг болтол Өвөр Монголын эрчим хүчний систем бид нарт өгөхгүй байгаа. Үнэн. Энийг тодорхой болгож байж эцсийн дүнд “Оюутолгой” компанийн цахилгаан эрчим хүчний өртөг тодорхой болно. Үүнээс шалтгаалаад бүтээгдэхүүн баяжмалын үнэ гээд Монголын талын өгөөж, ноогдол ашиг гэдэг юмнууд яригдана. Тэгэхээр энэ асуудлыг хүссэн, хүсээгүй тэр Өвөр Монголын эрчим хүчний системтэй бас шийдэх ёстой ийм л байна. Хувь аж ахуйн нэгж маань бид нар Эрчим хүчний яамны зүгээс бас энэ тарифыг эцэслэн тохирьё, хугацаатай тогтворжуулья гэдэг ийм хүсэлтүүдийг Хятадын талд хүргүүлээд байгаа.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүнийг нэмье. Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Энэ Монгол Улсад нийт 49 төрийн өмчит компани байдгийн 528 нь болохоороо ТУЗ-ийн гишүүдээр ажиллаж байгаа юм байна. Тэгэхээр 528 ТУЗ-ийн гишүүнтэй. Тэрний 103 нь болохоор эрчим хүчний салбарын ТӨК-удын ТУЗ-ийн гишүүд байгаа байхгүй юу. Тэгээд хараад үзэхээр энэ эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа эзэмшигч нь болохоор Эрчим хүчний яам 66 хувь нь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34 хувийг эзэмшиж байгаа. Тэгэхээр энэ ТУЗ-ийн гишүүд нь ерөөсөө дандаа эрчим хүчний салбараасаа шууд томилогдоод ажиллаж байгаа хүмүүс байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс үнэхээр яг тухайн компанийнхаа бодлогыг гаргаж чаддаг юм уу? Энэ хүмүүс үнэхээр бүтээмжтэй ажиллаж чадаж байгаа юм уу? Бид нар зайлшгүй энэ 103 ТУЗ-ийн гишүүдийг ажиллуулаад байх шаардлага байгаа юм уу?

Яагаад гэвэл бид нар эрчим хүчний салбарын бүтээмжийн талаар ярих шаардлагатай болчхоод байна л даа. Тэгэхээр бодлого тодорхойлоход оролцож

байгаа ТУЗ-ийн гишүүд тэнд хариуцлагатай ажиллах ёстой хүмүүс шүү дээ. Гэтэл энэ хүмүүс маань ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээхгүйгээр ингээд яваад байгаа юм шиг байдал байна л даа. Эхний асуулт энэ байна.

Хоёр дахь асуулт болохоор энэ нийслэлийн 2040 он хүртэлх нэгдсэн төлөвлөлт батлагдаад явж байна. Энд юуг нь хараад байж байна л даа. Тэгэхээр энэ дээр Эрчим хүчний яамнаас яг бодлого дээр нь оролцсон уу гэдэг асуулт байна. Тэгээд энэ дээр байгаа төлөвлөлтийг нь ингээд хараад үзэхээр мэдээж төвлөрсөн дулаан хангамж дээр байна, хэсэгчилсэн дулаан хангамж дээр болохоор 15 цэгт дулааны станцууд барина гэж оруулсан байгаа. Тэр 15 цэгээ хараад үзэхээр тэр чинь томоохон хэмжээний уурын зуух л байгаа шүү дээ. Тийшээгээ нүүрсээ автомашинаар зөөгөөд, тэгээд тэндээсээ гарах үнсийг нь бас ингээд зөөгөөд явдаг тэр логистикийг нь үнэхээр яг та бүхэн тооцсон уу? Энэ дээр яг ямар бодлого баримталж байгаа юм бэ? Энэ үнэхээр зөв юм уу гэдэг дээр бас гайхаж байна.

Тэгээд 70 хувийг нь болохоороо хатуу түлшээр хангана гээд оруулаад өгчихсөн байгаа юм. Тэгэхээр энэ хатуу түлш гэдгийгээ юу гэж ойлгож байгаа юм бэ? Энэ яг нийслэлийн гаргасан бодлого юм уу, Эрчим хүчний яамнаас гаргаад өгчихсөн бодлого юм уу? Ер нь нийслэл тусдаа бодлоготой байгаад байгаа юм уу? Энэ чинь бас их сонин байдал үүсчээд байна л даа. Хаанаа шийдвэр нь гараад байгаа юм гэдэг нь тодорхойгүй байна.

Сүүлийн асуулт нь болохоороо Диспетчерийн үндэсний төвөөс мэдээллүүд ерөнхийдөө би цуглуулаад авлаа. Диспетчерийн үндэсний төв дээр хийгдсэн байгаа энэ худалдах, худалдан авах гэрээний үндсэн үзүүлэлтүүдийг нь сэргээгдэх эрчим хүчтэй, сэргээгдэхийн гэрээнүүдийг аваад харж байна. Дээрээс нь болохоороо Диспетчерийн үндэсний төвийн яг сүүлийн 8 жилийн төлөвлөгөө, тайлангуудыг нь бас аваад харж байна. Эндээс маш олон, 1 асуултаар асуух боломжгүйгээр Диспетчерийн үндэсний төвтэй холбоотойгоор маш олон асуудлууд байгаа юм байна гэж харагдаж байна. Эндээс бас нэг юм харахад Баянгийн 660мвт-ын-ын станц 27 онд болохоор 330мвт-ын орох юм байна. Тэгэхээр Диспетчерийн үндэсний төв дээр тариф энэ тэр тогтохдоо яаж тогтох вэ? Энэ чинь хэдэн жилээр гэрээг нь хийсэн байгаа вэ? Бид нар тархмал эх үүсвэрийг дэмжинэ гэж хэлж байгаа юм байж байж 660мвт-ын ийм том хэмжээний станцыг дэмжиж ажиллах бодлого баримтлах нь хэр зүй?

Р.Сэддорж: 4 номер. Хариулт Чойжилсүрэн сайд. Батсүмбэрэл гишүүнийг нэмээрэй.

С.Цэнгүүн: Цэнгүүн гишүүний асуултад хариулья.

Компанийн тухай хуулиараа Цэнгүүн гишүүн ээ заавал ТУЗ-тэй байна гэсэн Монгол Улс хуультай. 2018 онд байх энэ Төрийн өмийн хороон дээр байж байгаад энэ 20 эрчим хүчний салбарын 27 ТӨК-ийг 66 хувь нь дийлэнх олонх хувьцааны эрх нь бол Эрчим хүчний яам дээр шилжиж ирсэн юм байна лээ. Яагаад шилжиж ирсэн юм бэ гэхээр Төрийн өмийн хорооноос бас мэргэжлийн бус хүмүүсийн удирдлагатай байж байгаад Монгол Улс тухайн үед тэг зогссон. Азаар дулааны улиралд байсан юм гэнэ лээ.

Тэгээд намайг сайд болоход уже энэ асуудал шийдэгдсэн ийм байдалтай явж байгаа юм. ТУЗ-гүй байна гэж байхгүй. Компанийн тухай хуулиараа ийм

асуудал ярьж байгаа. Энэ хүмүүс хариуцлага хүлээгээд явж байгаа. Ямар ч байсан энэ хуучирчихсан энэ тоноглолуудыг бол бүрэн хүчин чадлаар нь энэ эрчим хүчний салбарын залуучууд ажиллуулаад явж байгаа шүү дээ. ТУЗ дээр нь хяналтыг нь тавьж байгаа, шахаж байгаа. Энэ хүмүүсийг бас улс төржүүлээд янз бүрийн байдлаар хүмүүс ярьж байх шиг байна. Энэ хүмүүс ажиллаж байгаа. Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийнх нь хажууд аудитуудад нь бий. Зорилтот түвшнийг нь баталж өгч байгаа, бизнес төлөвлөгөөг нь баталж өгч байгаа, хяналт тавьж байгаа. Энэ Компанийн тухай хуулийн дагуу энэ хүмүүс ажиллаж байгаа.

Эрчим хүчний яамнаас энэ хатуу түлш гэдэг чинь нүүрсийг хэлж байгаа болов уу. Хотоос ийм манайх наадах бичиг баримтын боловсруулалтад манайхаас санал авсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ бид нар чинь аливаа бичиг баримтыг боловсруулахын тулд хэд хэдэн удаа зөвшилцдөг ийм сэдэв. Тэгэхээр энэ нүүрсийг хүссэн, хүсээгүй сүүлийн жилүүдэд, ойрын жилүүдэд нүүрсийг оруулж дулаан үйлдвэрлэхгүй бол сая би энд бусад гишүүдийн асуултад хариулахдаа хэлсэн газаар үйлдвэрлэсэн дулаан бол нүүрсээр үйлдвэрлэсэн дулаанаасаа доор хаяж 3 дахин өндөр байна. Аргагүйн эрхэнд ингэж байгаа юм. Улс орны маань эдийн засаг сайнгүй байгаа учраас, иргэдийн маань орлого сайнгүй байгаа учраас ийм нөхцөлд хэдэн жил амьдрахаас ондоо аргагүй. Энэ хооронд эдийн засгийнхаа чадавхыг дээшлүүлээд, санхүүгийн чадвар маань гайгүй болоод, иргэдийн орлого дээшлээд, нийт улсын эдийн засаг явах юм бол тэр хэмжээгээрээ газ болон энэ бусад экологит энэ төслүүд рүү шилжээд явах болов уу гэсэн ийм тооцоололтой байгаа. Миний байр суурь ийм байгаа.

Баянгийн цахилгаан станц гээд ингэж байна. 660мвт-ын-ын хүчин чадалтай ийм станцыг сая сонгуулийн дараа 1 киловатт цагийг нь сүлжээнд нийлүүлэх хүн 8.4 центээр баталж өгсөн. Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний зохицуулах хорооноос хамтарч сын ажлын хэсэг гараад сүүлийн 2 жил бид нар тооцоолол бодсон ийм байгаа.

Бөөрөлжүүтийн цахилгаан станцын тухайд бол 16 оны 3 сард баталсан юм байна лээ 8.95 центээр, энэ Баянг бол 8.4 центээр баталж өгсөн байгаа. Таны тэр хэллээ тархмал эх үүсвэр гээд ингэж байна. Энэ яг үнэндээ бол 8.4 центээс хямдханаар үйлдвэрлэчихдэг юм, тогтвортой эрчим хүч шүү. Тогтвортой. Диспетчерийн удирдлагад ордог ийм одоохондоо өнөөдрийн байдлаар яг Монголын нөхцөлд бол энэнээс хямдхан эх үүсвэр олдохгүй байгаа юм.

Одоо ингээд элдэв зовлон тайлбар хийгээд суугаад байлтай биш. Ямар ч байсан энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц 600мвт-ын, Баян дээр 660мвт-ын станцуудыг эхлүүлсэн. Баянгийн станц бол 1.3 тэрбум долларын хөрөнгө оруулалттай юм байна лээ. Бүрэн гадаадын компанийн хувийн хөрөнгө оруулалтаар орж байгаа. Монголын төр ямар нэгэн тийм үүрэг хүлээхгүй, өр үүсгэхгүй байгаа ийм л төсөл байна лээ.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ нийслэлээс гаргаж байгаа бодлого нь, Эрчим хүчний яамнаас гаргаж байгаа бодлого хоёр өөр байгаа юм байна тийм үү? Таны саяын хариултаас сонсоход энэ хоёр?

Р.Сэддорж: Хариулт 4 номер сайд.

Б.Чойжилсүрэн: Нийслэлээс гаргаж байгаа бодлого уул нь салбарын яамнуудаас санал авдаг. Бид нар саналаа хүргүүлсэн. Гэхдээ бидний санал яг яаж туссан бэ гэдгийг бид нарт эргэж мэдэгдэхгүйгээр чиний барьчихсан байгаа, энийг бол би анх удаа харж байна.

Р.Сэддорж: Та бүхэн бол энэ Монгол Улсын эрчим хүчний салбарыг толгойлж байгаа удирдлагууд. Тэгээд ард түмэндээ энэ ая тухтай амьдралыг, орчныг бүрдүүлэх талаас хэр ажиллаж байна вэ? Хэдий болтол энэ эрчим хүчний хомсдолд орж, захын гэр хорооллууд цахилгааны хомсдолд орж, цахилгаан бараа нь шатаж, хашаандаа сайхан амьдрах боломжгүй байх вэ? Энд хугацаа байна уу? Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр бэлдэж байна л гэж дандаа ярьдаг. Тэгээд үр дүн нь хэзээ гарах бол? Цаг нь болчихоод байгаа юм биш үү? Аймгийн төвүүд байнга эрчим хүчний дутагдалтай байгаа. Шилжилт хөдөлгөөнийг бууруулъя төвлөрлийг сааруулъя гээд Засгийн газраас маш олон арга хэмжээ авч байгаа. Аймгийн төв дээр очиж амьдрах хүмүүсийн цахилгааны энэ асуудал, аймгийн төвийн хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад ерөөсөө л энэ эрчим хүчний дутагдлыг шийдэх асуудал байгаа. Улсын Их Хурлын гишүүд байнга энэ аймгийн төвүүдийн цахилгааны станцыг барья, шинээр байгуулъя, нэмье гэдэг саналуудаа гаргаж байгаа. Хөгжлийн төлөвлөгөөнд ч оруулж байгаа, 25 оны төсөв хэлэлцэхэд ч тэр, энэ цахилгаан станц барих, байгуулах асуудлуудыг оруулах гэхээр яам бас л хөдөлж өгөхгүй байх санагдаад байдаг юм. 21 аймагтаа яамныхаа 21 хүнийг хариуцуулаад ч юм уу энэ төслийг эрчимжүүлэх талаар та бүхэн яагаад арга хэмжээ авч болдоггүй юм бэ? Та бүхэн ерөөсөө хөдөлдөггүй, аймгаас санал ирвэл жоохон хөдөлчөөд л ингээд байдаг. Энэ аймгуудын цахилгааны хомсдолыг яг ямар төлөвлөгөө гаргаад шийдэх тийм төлөвлөгөө байна вэ? Цаашдаа танай яам бодлогоо барьж явах уу? Сангийн яам бас илүү бодлого бариад яваад байна уу эрчим хүчний бодлого дээр? Тэгээд энэ дээр та бүхэн маань бас тодорхой хариулаач.

Б.Чойжилсүрэн: Сэддорж даргын асуултад хариулъя.

2027 он оны 6 сарын 30 хавьцаа бид нар Монголын дотоодоосоо бид нар эрчим хүчээ бүрэн хангадаг, хэрэглээгээ гүйцэт чадал нь урд талд нь орно гэдэг ийм тооцоололтой байгаа. Гэхдээ манай эрчим хүчний хэрэглээ ойрын 10-аад жилийн дотор жил болгон чадлын хувьд 12 хувиар өсөх учраас энэ маань орилж байгаа 300мвт-ын гээд, жил болгон ийм эх үүсвэрээр нэмж явж байж бид нар энэ эрчим хүчний салбар чадлын дутагдлаас сэргийлж чадах ийм бололцоо гэсэн үг 27 он. 2027 оны 6 сарын дунд гэхэд хэрэглээгээ гүйцэх болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Эрчим хүчний салбар 1 цахилгаан станцыг эхлүүлэхэд хамгийн багадаа ажил нь эхлээд 30 сар, ер нь 36 сарыг нь ийм дэлхий дээр угсарч ашиглалтад оруулахад ийм хугацаа шаарддаг юм байна. Тэгэхээр 27 оны 6 сарын 30 гэхэд ашиглалтад оруулахаар ийм тооцоололтой явж байгаа.

Энэ харамсалтай нь танай аймгийн тухайд Сангийн сайдтай бид хоёр яриад танай аймгийн төв дээр 50мвт-ын дулааны станц ДЦС, дулааныхаа хүчин чадал явдалтай нь ингээд яваад 2025 оны төсөв дээр суулгаад оруулах гэсэн чинь таныг бид нар бид хоёр дуудаж урьж уулзсан. Зураггүй гэдэг шалтгаанаар улсын 2025 оны улсын төсөв өргөн барихад Сангийн яаман дээрээс энэ төсөл хасагдсан. Та мэдэж байгаа. Одоо энэ сая 2025 оны төсөв батлагдсаны дараа аймгууд дээр, нийслэл дээр гаргаж байгаа бонд шиг Өмнөговь аймаг дээр жишээлбэл бонд гаргах юм бол энэ төслийг 2025 онд нь эхлүүлээ гэхэд сая миний хэлсэн хугацаанд буюу ойролцоогоор 36 сарын дотор энэ Даланзадгадын ДЦС

ашиглалтад баригдаж дуусах болов уу гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Ирэх жилийн төлөвлөгөөг Өмнөговь аймаг төсвөө батлахдаа энэ холбогдох өөрчлөлтүүдийг Сангийн яамтай зөвшилцөөд оруулах хэрэгтэй гэж ийм байр суурьтай байгаа.

Р.Сэддорж: Бусад аймгууд ер нь эрчим хүчний дутагдалгүй юу гэж ойлгох уу?

Б.Чойжилсүрэн: Монгол Улс нэгдсэн сүлжээнд холбогдож байгаа учраас бусад аймгууд ялгаагүй бүгдээрээ аймгийн төв ч ялгаагүй, сум ч ялгаагүй, Улаанбаатар хот ч ялгаагүй нэг сүлжээнд байгаа учраас бүгдээрээ цахилгааны дутагдлаас 27 онд гарна.

Р.Сэддорж: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Би эрчим хүч нарийн сайн мэдэхгүй, инженер хүн биш учраас сайн салбарын асуудлыг сайн мэдэхгүй байх. Зүгээр улс төрийн чанартай маягийн асуулт асууя. Нэг сайн юм харагдаад байгаа эрчим хүчний салбар дээр. Тэр нь юу вэ гэхлээр сайд нь хариулаад байгаа. Өөрөөр хэлэх юм бол олон толгой байхгүй байгаад байгаа гэж л харагдаж байгаа юм л даа. Зарим салбар дээр чинь бараг сайдынхаа урдуур орж ирээд баруун тийшээ хариулчихдаг хүмүүс бас байна. Орж ирээд зүүн тийш нь аваад явчихдаг хүмүүс байна. Эрчим хүчний салбар дээр энэ харьцангуй гайгүй байх шиг байгаа.

Тэгэхлээр энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гээд бид нар том зорилт дэвшүүлчихсэн. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай хамт эрчим хүчний сэргэлт гээд том бодлого дэвшүүлчихсэн. Энэ бид нарын том цөм асуудал байгаа. Энэ зорилт ер нь хэрэгжих үү? Нэгдүгээр асуулт. Энэ зорилтууд хэрэгжих үү?

Хоёр дахь асуудал нь ер нь эрчим хүчний салбар дээр энэ гишүүд сая асуугаад байсан бодит байдлыг нийтээрээ бид нар мэддэг болчихлоо. Ямархан хэмжээний өртгөөр эрчим хүчийг үйлдвэрлээд, ямар хэмжээний өртгөөр буцааж, худалдаж, зөрүүг нь өр, өртөг болж үлдэж байна вэ гэдгийг бас ойлгодог болчихсон байна. Харин цаашаа үүнийг жоохон зоригтой шийдвэрлэх шаардлагатай байна. Араас нь жоохон хөөцөлдөх хэрэгтэй байна. Энэ салбарын яамны чадавх ер нь хэр байгаа юм бэ? Салбарын яам, салбарын байгууллагуудын чадавх хэр байгаа юм? Үүнийг хийж, шийдэж чадах уу? Тэгээд бүх юман дээр сайдынхаа араар орж нуугддаг хүмүүстэй болчихсон юм биш биз дээ? Одоо бас сайд ганцаараа бүхнийг урдуураа барьж үзээд байгаа нь сайн мөртөө, муу юм нь араар нь нуугддаг хүмүүстэй болчихсон, тэгээд юм гарахаар зугтаачихдаг ийм болчих вий Чойжоо сайд аа. Тэгээд энэ нэгдмэл байдал, дайчин байх байдал, ил тод, ойлгомжтой байх, стандартад нийцүүлэх гэдэг асуудлууд маань энэ багийн хамт олонтой их холбоотой асуудал байх шиг байгаа юм. Энэ дээр салбарын чадавх хэр байгаа юм?

Дараагийн асуудал энэ түлшний асуудал сүүлийн үед их яригдаж байна. Улаанбаатар хотын утааны асуудал, Улаанбаатар төдийгүй аймгуудын төвүүдийн, суурин төвүүдийн утааны асуудлууд маш хүчтэй яригдаж байна. Энэ утаа, түлшний асуудал ганц салбарын асуудал биш. Энэ салбар дундын асуудал. Өөрөөр хэлэх юм түлш гэдэг Эрчим хүчний яамны асуудал. Барилга гэдэг түүнээс шийд гарах гэж байгаа барилгажуулах асуудал нь барилгын яамны асуудал, иргэд өөрсдөө мөнгө, төлбөрөө төлөх асуудал нь Сангийн яамны асуудал, төлбөрийн

чадвартай байх уу, байхгүй юу гэдэг нь Эдийн засаг, хөгжлийн яамны асуудал гээд энэ салбар дундын бодлогыг та бүхэн хэрхэн уялдуулж байна? Ганц Эрчим хүчний яам дангаараа марафонд яваад байна уу? Бусад нөгөө барилгажуулах, барилга авах гэж байгаа хүмүүсийг чадавхтай байлгах яамнуудаа хэр уялдаж байна вэ?

Р.Сэддорж: 1 минут нэмье Батсүмбэрэл гишүүнд.

Н.Батсүмбэрэл: Тэгээд энэ ганц Улаанбаатар хот биш ээ, аймгийн төвүүд, суурин, томхон сууринууд утаатай болчихлоо. Ялангуяа шинэ хэрэглэгч, том хэрэглэгчид нэмэгдэж байна. Энэ дээр энэ бүсчилсэн хөгжлийн бодлоготойгоо уялдуулж та нар хэрхэн харж байна? Энэ асуудлыг шийдэх тэжээлийн эх үүсвэрүүдээ, шугамын хүчин чадлуудаа, шугамын найдвартай байдлуудаа энийг яаж харж байна вэ гэдгийг асууя. Жаргалан гишүүн асуугаад байсан Төв аймгийн Баян сумд байгаа тэр дулааны станц ямар компани байгаа юм бэ гэдгийг бас хариулж өгөөч ээ гэж байна. Ийм асуултууд байна.

Р.Сэддорж: Хариулт хэд вэ? 4 номер ,Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Батсүмбэрэл гишүүн ч голдуу санал хэлчихлээ. Цөөхөн асуулт асуух шиг боллоо. Салбарын яамны чадавх сайн гэж өөрсдийгөө магтаад байх юм байхгүй. Сурах ёстой, цэгцрэх ёстой, цаашаа дандаа шинэчилж өөрчлөгдөж байх ёстой. Энэ бол амьд организм учраас тэнд энэ асуудлуудыг ярина. Бидний тухайд бол бид нар өөрсдөө дүгнэлт өгөөд байх нь утга муутай байна. Ямар ч байсан эрчим хүчний салбар Монгол Улсын гал голомтын манаанд энэ 20 мянган хүн бол зүрх сэтгэлээрээ нойр хоолоо хасаад, байгаа боломждоо гайгүй ажиллаж байгаа гэж бодож явдаг. Би бас энэ сүүлийн 3 жил Эрчим хүчний сайдад хийлээ. Энэ өвөл болохоороо манай салбар чинь онцгой нөхцөл байдал үүсээд л тэгээд л нойр хоолоо хасаад л явдаг ийм л улсууд байгаа. Мэдээж бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад хоцрогдсон, чадахгүй, мэдэхгүй зүйлүүд их байгаа. Энийгээ бид нар ухамсарлаж байгаа. Өөрчлөлт, шинэчлэлт рүү бол бага багаар ямар ч байсан явна гэдгээ бол ийм тод тооцоололтой байгаа гэдгийг хэлье.

Энэ салбар дундын асуудлууд мэдээж нэг Засгийн газар салбарын яамнууд хоорондоо уялдаж ажиллах ёстой, орон нутгуудтайгаа уялдаж ажиллах ёстой. Энэ дээр бид нар бол манай яамны тухайд бол ямар бусад яамнуудтай, бусад салбаруудтайгаа, бусад орон нутгийнхантайгаа бол ямар нэгэн тийм зөрчил байхгүй. Аль болох болгоё, бүтээе, нээлттэй хамтарч ажиллах ийм л зарчим баримталж байгаа.

Энэ Баянгийн цахилгаан станцыг барьж байгаа компани гадаадын хөрөнгө оруулалтыг “Касэн” групп гэдэг нэртэй компани барьж байгаа юм гэсэн.

Р.Сэддорж: Тодруулъя Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Тэр салбар дундын асуудал дээр тодруулж байгаа юм байна. Жишээлбэл, Энх-Амгалан сайд ингээд Үндэсний хороо гээд байгуулаад байх шиг байгаа юм. Тэгтэл баахан барилга барих гээд байдаг, түүний тэжээлийн эх үүсвэр байгаа юм уу? Шугамын хүчин чадал хэр байгаа юм? Уг нь энэ дээр чинь Эрчим хүчний сайдын дуу хоолой нэлээн хүчтэй баймаар байгаа юм. Энэ дээр та ямар бодолтой байгаа юм гэдэг ийм асуулт байна.

Хоёрт нь тэр та яасангүй, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд аймаг орон нутгууд болон шинэ, том хэрэглэгчдийнхээ эх үүсвэрийг хэсэгчилсэн эх үүсвэрээр яаж шийдэх бодлого барьж байна вэ?

Р.Сэддорж: 4 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Хамгийн том хүндрэлтэй сэдэв бол энэ цахилгааны эрчим хүчний дутагдалд орчихсон байгаа.

Хоёрдугаарт, Улаанбаатар хот дулааны эрчим хүчний хувьд асар том дутагдалтай болчихсон байгаа. Суурилагдсан хүчин чадлаасаа бараг 50 хувь, илүү хүчин чадал холбогдчихсон. Хамгийн хүндрэлтэй цэгүүд бол Улаанбаатар хот дээр байгаа.

Мэдээж аймгийн төвүүд дээр бол дулааны эх үүсвэр дутагдалтай асуудлууд бий. Үе шаттай бага багаар шийдээд явж байгаа. Гэхдээ Улаанбаатар шиг яг ийм улаан гэрэл асаад ийм дутагдал, чадлын дутагдалд орчихсон газруудад Монголын бусад суурин газруудад арай гайгүй байгаа. Аймгийн төвүүд. Мэдээж гэхдээ энэ хөрөнгө оруулалтыг бол үе үеийн удирдлагууд, үе үеийн Эрчим хүчний яамнаас бас анхаарах хөрөнгө оруулалт хийгдээд явах байх. Одоо 10 аймгийн дулааны станцыг ямар ч байсан энэ төсөл маань бараг дампуурч явсныг бид нар ингээд Солонгос Улсын Элчин сайдын.../минут дуусав./

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Бадамсүрэн гишүүнээр нэр тасалж байна. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Манай Улс бол эрчим хүчний эх үүсвэрийн эх орон, нүүрсний эх орон, нар салхины эх орон. Тэгсэн атлаа өнөөдөр 2024 онд, 25 он гарах гэж байхад гэртээ лаа барьцгаагаад суугаад байгаа. Тэгээд дандаа ийм зовлон яриад сууж байгаа. Тэгэхээр өнгөрсөн 34 жил бид нар зах зээлд шилжсэнээс хойш үнэхээр яг энэ салбарт ахиц дэвшил гарч чадсангүй. Тэгээд одоо болохлоор эрчим хүчний реформ энэ тэр гээд л бас ийм гоё ганган нэр томьёонууд яриад байгаа хэр нь бас дахиад ирэх 30 жилд энэ эрчим хүчний салбарыг мухардалд оруулах зүйлүүд хийгээд байгаа юм биш биз дээ гэсэн бас болгоомжлол төрж байна.

Яагаад гэхлээр жишээлбэл сая таны дурдсан дээр 2 том төсөл гэхэд л 28 жил, 30 жилийн гэрээтэй 8, 9 центийн үнэтэй, тэгээд манай нийт хүчин чадалтай тэнцэхүйц ийм төслүүдтэй ингээд 20,30 жилээр гэрээ хийгээд байна. 20, 30 жилийн дараа, 28 жилийн дараа та бид нарын хэн нь ч энд байхгүй.

Гэтэл энэ хугацаанд Монгол Улсын энэ эрчим хүчний үнийг ингэж айхтар өсгөх, үнэхээр бид нарын бас манай улсын ийм харьцангуй давуу талыг ингэж үнэгүйдүүлэх зүйл хийчхээд яаж бид нар дараа нь ер нь ийм үйлдвэрлэгч улс орон болох юм бэ? Яаж бид экспортлогч улс орон болох юм бэ? Эрчим хүчний үнэ гэдэг бол бүх үйлдвэрлэлийн суурь үнэ байдаг.

Тэгэхээр бид зөвхөн ийм чадлын асуудал яриагүй, цаашлаад эдий эдийн засгийнхаа бүх асуудал дээр суурь үнэ болох зүйл дээр та нар өнөөдөр шийдвэр

гаргаад байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлууд дээрээ их тийм ул суурьтай шийдвэр гаргахгүй бол яг өнөөдөр л бид нар ингээд хөлдчих гээд байна, өнөөдөр л энэ чадал байхгүй болчих гээд байна, өнөөдөр л энэ өртөг нь үнээсээ өндөр байна энэ тэр гэсээр юм байгаад ийм болчимгүй шийдвэрүүд гаргачхаад дараа нь ингээд бүхий л эдийн засгаа, үйлдвэрлэлээ энэ тэр татаж унагах ийм зүйл рүү явчих вий, явчих юм биш биз дээ гэж бас санаа зовж байна.

Жишээлэх юм бол манай урд хөрш Хятад Ард Улсад болохлоор эрчим хүчний үнэ 7.5 цент байна. Индонез улс бас л нүүрсний экспортлогч улс. Эрчим хүчний үнэ 6.9 цент байна. Тэгэхээр та нар ингээд ийм 20, 30 жилээр ахиад ирэх, ирээдүйд бий болох эрчим хүчний үнийг 9 цент дээр барих гээд байна шүү дээ дор хаяж. Тэгэхээр чинь энэ чинь манай өрсөлдөх чадварыг үгүй хийнэ шүү дээ, бусад салбарууд дээр.

Тэгэхээр тэрийгээ бас тооцож байгаа юм уу? Тэн дээр, үгүй ээ тэгээд тэрийг тэгвэл дараа нь тэрийг хоёулаа ярья. Тэгэхдээ бид нар хар аа, Монгол Улс ийм их нүүрсний нөөцтэй, ийм их эрчим хүчний эх үүсвэрийн нөөцтэй байж байж ийм өндөр үнэтэй эрчим хүчтэй болж болохгүй. Тэгэхээр тэрийг та нар арай өөр утгаар нь бас хараарай гэж хэлэхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Асуулт, хариулт явахгүй. Дэгээ барина. Батсүмбэрэл гишүүнийг нэмээрэй. Одоо Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Олон гишүүн оновчтой асуулт асууж байна л даа. Ер нь айлын аав хүн эхлээд гэрийнхээ цахилгааны мөнгийг л төлнө л дөө. Хүүхдүүдээ гэрэлтэй, гэгээтэй хичээл номоо хийж, хоол ундаа хийхийн тулд. Тийм учраас энэ цахилгаан эрчим хүчний асуудал дээр Монголын төр гэж байгаа онцгой анхаарах ёстой. Шинэ сэргэлтийн 6 бодлогын нэгдүгээрт боомтын сэргэлт, хоёрдугаарт нь эрчим хүчний сэргэлт байгаа. Энэ бол эдийн засгийн хөгжлийг боомилж байгаа, саад болж байгаа зүйлийгээ арилгая гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр би Чойжилсүрэн сайдад ямар санал хэлэх гээд байна гэхээр энэ эрчим хүчний асуудлаа энэ Эрчим хүчний яам өөрөө ингээд манлайлаад аваад байж болохгүй юм уу? Би нэг зүйлийг гайхаад байгаа юм. Энэ Эрчим хүчний үндэсний хороо гэж байгуулаад ХҮН намын дарга, Шадар сайд Доржханд ахалсан юм уу даа янз нь. Тэгээд энэ сая эхлээд төсөв батлахад энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, хэвлэл мэдээллийн зардал чинь өндөр байна, энэ тийм хэмнэж болох зардал аа, энэ заавал байх шаардлагагүй ээ гээд үзээд байхад зөрүүлээд дахиад улсын төсөв 2 дахиа Засгийн газар өргөн барихад ингээд 10 гаруй тэрбум төгрөг гээд ингээд оруулаад ирсэн.

Тэгээд тэрийг нь анх энэ Цэнгүүн гишүүн нийгэмд анх дэлгэсэн, дараа нь Баттөмөрийн Энхбаяр гишүүн энэ тодорхой албан бичиг Сангийн яам руу явуулсан бичгийг нь дэлгэсэн байна лээ. Тэгээд ингээд ийм мэдрэмжгүй байгаад байх юм уу сайд нар? Эсвэл ингээд өөрийн толгойгүй байдаг юм уу, эсвэл ерөөсөө ингээд энэ хэн хэлэх вэ, хэн юу хэлэх вэ, намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ гээд ингээд яваад байдаг юм уу? Тэгээд би энийг гайхаад байгаа юм. Яах вэ салбар хоорондын уялдаа холбоог хангая гэдэг бодлого байгаагүй ойлгож байгаа.

Гэхдээ Чойжилсүрэн сайд Сангийн сайд байсан, Эрчим хүчний сайд байгаа, өөрөө бас хувийн хэвшлийг мэдэх хүн. Тэгээд яах вэ, хүмүүс бас зарим

тохиолдолд ингээд инээдэм ханиадам болгоод байгаа юм. Уг нь Чойжилсүрэн сайд яг бодит үнэнийг л яриад байх шиг байгаа юм л даа.

Тэгээд би ямар санал хэлэх гээд байна гэхээр энэ Шинэ сэргэлтийн 6 бодлогын 2-т эрэмбэлэгдсэн энэ салбарыг ер нь маш сайн анхаарч, ингэж хүч нэмж, ингэж хүч түрж явахгүй бол тэгээд л ийм аргалсан байдалтай яваад байвал ингээд хүнд шүү дээ. Тэгээд би санаж байна саяхан л гэхэд сумдад дизель станц асаадаг 30, 60-ын хүчин чадалтай, тэгээд энэ сумдаа суурин газраа холбоно гэдэг асуудал саяхан л юм шиг санагдаж байна. Одоо бол эрин үе өөр болсон. Хүмүүс цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хүсэж байна. Хөгжлийг дэмжихэд энэ хамгийн хэрэгтэй.

Тэгэхээр энийг жоохон ингэж бодитой хандах тал дээр нь иргэдэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэх асуудлаа зөв явах ёстой. Түүнээс хэвлэл мэдээлэлд 10 тэрбум төгрөг тавиад ингээд явна гэсэн ойлголт байхгүй шүү дээ. Ярих нь яах вэ, ажил хийх нь чухал байна. Эх үүсвэр нэмэх хэрэгтэй байна. Дорнодод л сүүлийн жилүүдэд ганц цахилгаан станц 50мвт-аар баригдлаа шүү дээ. Өөр баригдсаныг би мэдэхгүй л байна.

Тэгэхээр энэ анхнаасаа ингээд 110-ын шугам бас барьчихаж байгаа юм. Тэгээд л Өндөрхаанаас Сүхбаатар гээд л. Уул нь 220-ийг өсөн нэмэгдэх хэрэгцээгээ бодож барих ёстой байсан. Харамч хүн 2 төлдөг гэдэг. Яг энэ шиг миний түрүүн асуулт асуусан санал ерөөсөө зөв төлөвлөөд, тэгээд энэ рүүгээ зоригтой энийгээ хийгээд яваач. Саад тотгор байвал тэрийг гэтлээд даван туулаад л явна шүү дээ. Эрчим хүчний би түрүүн бас л хэлсэн нисэх онгоцны буудал барина л гэж байдаг, метро барина л гэж байдаг хамгийн багадаа 3-аас доошгүй найдвартай ажиллагаатай эх үүсвэр хэрэгтэй.

Тэгэхгүй бол хүний амь нас, аюулгүй байдал гэдэг чинь 1 дүгээр асуудал. Тэгээд энэ зүйлийг ойлгуулахаас өгсүүлээд энэ зүйлүүдээ явуулах хэрэгтэй байна. Тэгээд энэ дээр маш сайн анхаарахгүй болохгүй шүү. Би тэгээд дахин хэлье. Улс орноо бас тог цахилгаантай байлгах нь хамгийн чухал. Тэгээд тэр ТӨК-уд Компанийн тухай хуулиар явдаг гээд байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар бас явах боломжтой шүү дээ. Заавал ТУЗ байх хэрэг байгаа юм уу? Энэ олон хэрэгт холбогдсон хүн.../минут дуусав./

Р.Сэддорж: Баярлалаа. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Санал дээр юу яая. Өмнөх тэр төсвийн хэлэлцүүлэг дээр ялт ч үгүй гарсан юм тэр Эрчим хүчний зохицуулах хороо гээд. Эрчим хүчний зохицуулах хороо нь тэгсэн мөртөө өөр сайдын багцад байдаг юм шиг байгаа юм миний ойлгосноор. Тэгэхээр энэ Эрчим хүчний зохицуулах хороог Эрчим хүчний яаман дээр нь аваачаад нэг толгойтой болмоор байгаа юм салбарын асуудлыг. Тэгэхгүй ингээд ойлгомжгүй байдалтай явж байх шиг байгаа юм нэгдүгээрт. санал шүү дээ.

Хоёрдугаарт нь хэд хэдэн удаа хэлэлцүүлэг дээр Чойжилсүрэн сайдыг байхгүй үед энэ салбарын хүмүүс олигтой хариулт өгөхгүй байгаа. Тэгээд Төрийн нарийн гэж хүн байна уу? Ямар хүн байдаг юм бол? Олигтойхон чадвартай, тамиртай, мэдлэгтэй тийм Төрийн нарийнтай болох хэрэгтэй юм шиг харагдаж байгаа. Энэ Сангийн яам, Эдийн засгийн яам шиг. Би Төрийн нарийг мэдэхгүй

учраас, асуултад хариулж байсныг нь ч хараагүй учраас би хэлж байгаа юм. Энэ дотор байгаа анхаарна биз.

Тэр Эрчим хүчний зохицуулах хорооны зардалд танагдаагүй юм шиг байгаа юм хэвлэл мэдээллээр, Шадар сайд ахалдаг юм шиг байгаа юм. Хүнээ боддог бодлого гаргана, иргэнээ боддог сайд байна гэж байсан. Тэгээд тэрийг нь бид нар хянах хэрэгтэй. Эдийн засгийн байнгын хороо яг энэ дээр тусгайлж, Эдийн засгийн байнгын хорооны даргад болон ажлын албанд хэлж байгаа шүү. Тэр Эрчим хүчний зохицуулах хорооны зардлыг тусгайлж авч, бичгээр авч хяналт тавих хэрэгтэй. Энэ зардлыг Сангийн яамнаас бичгээр авъя.

Дөрөв дэх асуудал тэр салбар дундын бодлого дээр манлайлмаар байна эрчим хүчний салбар. Ингэхгүй бол аваачаад барилга үйлдвэрлэгчид нь түрүүлээд байдаг, эс үгүй бол нөгөө зээл олгогчид нь түрүүлээд байдаг, эрчим хүч үйлдвэрлэгч нь хоцроод байдаг. Тэгээд сая яриад байгаа үнэн шүү дээ. Улаанбаатар хот маань гоё метротой болмоор байна, тог нь тасардаггүй болмоор байна, тогоо хязгаарлуулдаггүй болмоор байна, энд тэнд олон барилгажсан хотхонтой, хоттой болмоор байна.

Гэтэл бүх хязгаарлалт эрчим хүчнийхээ эх үүсвэр дээр очоод явчхаад байгаа. Аргаа ядсандаа дэд төвүүд байгуулаад байгаа. Тэгэхээр энэ Эрчим хүчний яам маань энэ дээр эрчим хүчний тэжээл, чадал, эх үүсвэрт тулгуурласан бүсчлэх, хөгжүүлэх дүгнэлт, зөвлөмжийг гаргаж Эдийн засгийн байнгын хороонд ирүүлээч. Улаанбаатар хотыг хаана нь барилгажуулбал эрчим хүчний төвийн шугам, хэсэгчилсэн шугам хүрэх вэ, тархмал эх үүсвэрүүд хүрэх вэ, боломжтой вэ, хаана нар тусах юм, хаана салхи салхилах юм? Нөгөө салхиа мэдэхгүй аваачаад сэнсээ тавьчихдаг, нар очихыг мэдэхгүй аваачаад панелаа угсарчихдаг байж таармааргүй байна.

Тэгэхлээр энэ дээр Эрчим хүчний яам зөвлөмж өгмөөр байна. Сэддорж дарга энэ дээр яг тусгайлаад Эрчим хүчний яамнаас Улаанбаатар хотыг болон Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх асуудал дээр Эрчим хүчний яамнаас дүгнэлт, зөвлөмж авъя, энэ дээрээ үндэслэж бид нар дараагийн бодлогуудаа гаргая, энэ дээрээ үндэслэж бид нар төсвөө эрэмбэлье, энэ дээрээ үндэслэж бид нар хөрөнгө оруулалтаа эрэмбэлье, эрчим хүчин дээрээ тулгуурлаж хэдүүлээ бодитойгоор ажиллацгаая. Эрчим хүч байхгүй газар бид нар бяслагийн үйлдвэр яриад яах вэ. Бодит амьдралтайгаа хэдүүлээ нүүр тулъя. Яг л ийм юмыг би та бүхэндээ хэлэх гэсэн юм. Тэгээд хэдүүлээ эрчим хүч буюу хөнжлийнхөө хэрээр хөлөө жийе. Хаана эрчим хүч байгаа нь тэндээ хэдүүлээ төвлөрч хөгжье. Энийг хийх хийхийн тулд Эрчим хүчний яам маш том мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Их Хуралд, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлээч ээ гэдгийг хүсье, захъя.

Р.Сэддорж: Түрүүнд зураг төсөвгүй гэдэг зүйл яригдаж байсан. Тэгээд эрчим хүчний станцыг зураг төсөвгүй энэ бас шалтаг байх л гэж бодож байгаа. Тэгээд энэ дээрээ бас яамныхан маань анхаараарай. Яамны гол зорилго энэ ард түмнийг эрчим хүчний хомсдолгүй л байлгах л гол зорилго л гэж бодож байгаа.

Ингээд Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

17.50 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР